



НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ
БАЙГУУЛЛАГА
МОНГОЛ УЛС



МОНГОЛ ДАХЬ НҮБ-ЫН АЖЛЫН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН, 2017-2020

НҮБ-ЫН ХӨГЖЛИЙН
ТУСЛАМЖИЙН ХҮРЭЭ 2017-2022



Гэрэл зургийг Б. Бямба-Очир / ОУДХБ

Агуулга

ӨМНӨХ ҮГ	2
МОНГОЛ ДАХЬ НҮБ-ЫН УДИРДЛАГЫН БАГ	3
МОНГОЛ ДАХЬ НҮБ-ЫН ХӨГЖЛИЙН СИСТЕМИЙН ХӨГЖЛИЙН ГОЛ ТҮНШҮҮД	4
1 МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА	7
2 НҮБ-ААС ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ҮЗҮҮЛСЭН ДЭМЖЛЭГ	10
2.1 ЕРӨНХИЙ ТОЙМ	10
2.2 ҮР ДҮНГИЙН ЧИГЛЭЛ НЭГ: ХҮРТЭЭМЖТЭЙ ӨСӨЛТ, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТИЙГ ДЭМЖИХ	15
2.2.1. Хөгжлийн алсын хараа, стратеги ба төлөвлөгөө	16
2.2.2. Уур амьсгалын өөрчлөлт ба түүнийг сааруулах	17
2.2.3. Экосистемийн үйлчилгээ	18
2.2.4. Гамшгийн эрсдэлийг даван туулах чадвар	19
2.3 ҮР ДҮНГИЙН ЧИГЛЭЛ ХОЁР: НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛАХ, ЧАНАРТАЙ, ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ БИЙ БОЛГОХ	20
2.3.1. Эрүүл мэнд	21
2.3.2. Ус, ариун цэвэр, эрүүл ахуй	22
2.3.3. Чанартай боловсролыг дэмжих	23
2.3.4. Хүнсний чанарыг сайжруулах	24
2.3.5. Нийгмийн хамгаалал	26
2.4 ҮР ДҮНГИЙН ЧИГЛЭЛ ГУРАВ: ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИЖ, ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ	27
2.4.1. Хууль эрх зүйн хамгааллын механизм	28
2.4.2. Эмэгтэйчүүд, залуучуудын төлөөлөл	29
2.4.3. Залуучуудын сүлжээ, байгууллагууд	30
2.5 2030 ОН ХҮРТЭЛХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН ТҮНШЛЭЛ БА САНХҮҮЖИЛТИЙН ДЭМЖЛЭГ	31
2.6 НҮБ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАРИЛЦАН УЯЛДАА, ҮР НӨЛӨӨТЭЙ БАЙДАЛ БА ҮР АШИГ	33
2.6.1. НҮБ-ын системийн байгууллагуудын эерэг үр дүнгийн төлөөх хамтын ажиллагаа ба харилцан уялдаа	33
2.6.2. Мэдээлэл харилцаа ба сурталчлан таниулах хамтарсан үйл ажиллагаа	33
2.6.3. Нийтлэг үйл ажиллагаа	35
2.7 САНХҮҮЖИЛТИЙН ТОЙМ БА ЭХ ҮҮСВЭР ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭЛТ	36
2.7.1. Санхүүжилтийн тойм	36
2.7.2. Санхүүжилтийн эх үүсвэр	39
3. НҮБ-ЫН УДИРДЛАГЫН БАГИЙН 2022 ОНЫ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ	40
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	41

ӨМНӨХ ҮГ



ТАПАН МИШРА

**Нэгдсэн Үндэстний
Байгууллагын Суурин
зохицуулагч**

Монгол Улс дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын 2017-2020 онд хийж хэрэгжүүлсэн ажлын үр дүнгийн тайлангаа үүгээр танилцуулж байгаадаа таатай байна. Юуны өмнө, Монгол Улсад хүртээмжтэй тогтвортой хөгжлийг ахиц дэвшилд хүргэхийн төлөө асар их хүчин чармайлт гаргаж ажилласан НҮБ-ын удирдлагын баг, хамт олон, нийт ажилтнууддаа чин сэтгэлээсээ талархал илэрхийлье. НҮБ-аас Монгол Улсын Засгийн газар, иргэний нийгмийн байгууллагууд, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд, олон улсын санхүүгийн байгууллагууд (ОУСБ), хөгжлийн түншүүд, Глобал төрөлжсөн сангууд (ГТС) зэрэг нэгжгээд тооны оролцогч талуудтай гойд сайн түншлэл, хамтын ажиллагаа өрнүүлсэн явдал энэхүү тайланд дэлгэрэнгүй авч үзсэн ажлын гүйцэтгэл, манай байгууллагын Монголын ард түмний өмнө хүлээсэн үүргээ үр дүнтэйгээр биелүүлэх баталгаа нь болж өглөө.

КОВИД-19 цар тахал хөгжлийн ололт амжилтад заналхийлсэн урьдаас төсөөлөөгүй гэнэтийн цочрол байв. Гэсэн хэдий ч НҮБ өөрийн түншүүдийн хамт энэхүү хүнд сорилтыг даван туулж, Монгол Улсын нүүр тулаад буй цар тахлын эсрэг үр дүнтэй хариу арга хэмжээ авч ирлээ. Монгол дахь НҮБ-ын баг хамт олон Нийгэм-эдийн засгийн хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, байгаа хөрөнгийнхөө хуваарилалтад өөрчлөлт оруулах, нэмэлт хөрөнгө босгох замаар 27.4 сая долларыг хурдан хугацаанд татан төвлөрүүлж чадлаа. Эдгээр хариу арга хэмжээний гол зорилго нь эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх, иргэдийг хамгаалах, Монгол түмний хүндрэлийг даван туулах чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдлээ.

НҮБ-ын системийн төрөлжсөн байгууллага хоорондын хамтын ажиллагааны үр нөлөө тасралтгүй өсч ирсэн явдал НҮБ-аас 2017-2022 онд үзүүлэх Хөгжлийн тусламжийн хүрээнд дэвшүүлсэн гурван үр дүнгийн чиглэлээр ахиц дэвшил гаргахад тус дөхөм үзүүлээ. Хамтарсан хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх замаар зардлыг бууруулж, ажлынхаа үр нөлөөтэй байдал болон үр ашгийг дээшлүүлж чадлаа.

НҮБ-ын хамтын хүчин чармайлтын үр дүнд, хүлэмжийн хийн ялгарлыг мэдэгдэхүйц бууруулах, тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр Монгол Улсын олсон ололт амжилтад өөрийн гэсэн хувь нэмрээ оруулав. Эдгээр хүчин чармайлт нь Монголын үзэсгэлэнт сайхан байгалийг харж мэдрэн баясгах боломжоор хангагдах ирээдүй хойч үеийнхэнд асар их нөлөө үзүүлэх нь дамжиггүй. Үүнээс гадна НҮБ-ын системийн байгууллагуудын хамтын хүчин чармайлт ажлын байр нэмэгдүүлэх (ялангуяа

Монгол улсын хөдөө орон нутагт), орхигдсон болон эмзэг бүлгийн хүн амд орлого олох боломжийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр орууллаа.

Цаашилбал, Монгол дахь НҮБ-ын баг, хамт олон нийгмийн хамгаалал, үйлчилгээг иргэдэд, нэн ялангуяа орхигдох эрсдэлтэй хүмүүст хүртээмжтэй байх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлд Монгол Улсын Засгийн газартай хамтран ажиллав. Бидний хамтын хүчин чармайлт Монголын бүх хүүхдүүд, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд чанартай боловсрол эзэмших орчныг бүрдүүлэх, иргэдийн дундах урьдчилан сэргийлж болохуйц эрүүл мэндийн эрсдэлийг бууруулахад хувь нэмэр орууллаа.

Үүгээр зогсохгүй, Монгол дахь НҮБ нь системийн байгууллагуудынхаа хамтарсан сурталчлан таниулах үйл ажиллагаа болон хөтөлбөрөөр дамжуулан эмэгтэйчүүд, залуучууд, хүүхдүүдийг чадваржуулах чиглэлээр Монгол Улсын Засгийн газартай хамтран ажиллав. Холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулж, тэдгээрийг хэрэгжүүлэх замаар Монгол Улсад хүний эрхийг эрхэмлэн дээдэлж, жендэрийн тэгш байдлыг хангахад бид бас хувь нэмэрээ оруулсан болно.

Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-ыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор НҮБ-аас үзүүлж ирсэн дэмжлэг тусалцаа гол төлөв чадавхыг бэхжүүлэх, техникийн тусалцаа үзүүлэх, бодлогын зөвлөгөө өгөх, түншлэл, мэдлэг хуваалцах, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх замаар хийгдэж ирлээ.


Гэсэн хэдий ч хүртээмжтэй өсөлт, зохистой ажлын байр бий болгох, ядуурал, тэгш бус байдлыг бууруулах, чанартай боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, эмзэг бүлэгт анхаарлаа төвлөрүүлэх, хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх зэрэг хэд хэдэн чиглэлд илүү их анхаарал хандуулах шаардлагатай хэвээр байна. Хөгжлийн бодитой ололт амжилтанд хүрэхийн зэрэгцээ эдгээр саад бэрхшээлийг үр дүнтэй шийдвэрлэхийн тулд бүх оролцогч талуудын хамтын ажиллагаа шаардагдана.

Монгол улсыг КОВИД-19 цар тахлын сөрөг нөлөөллийг бууруулж, тогтвортой хөгжлийн зорилгод хүрэхэд нь НҮБ нь дэмжлэг үзүүлэн, хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн ажиллана.

МОНГОЛ ДАХЬ НҮБ-ЫН УДИРДЛАГЫН БАГ

СУУРИН ГИШҮҮД

Монгол улс дахь НҮБ



Тапан Мишра
НҮБ-ын суурин зохицуулагч

ХХААБ



Винод Ахужа
Төлөөлөгч

НҮБ-ын ХХ



Элейн Конкиевич
Суурин төлөөлөгч

НҮБ-ын ХАС



Каори Ишикава
Тэргүүн

НҮБ-ын ХС



Алекс Хайкенс
Төлөөлөгч

ДЭМБ



Сергей Диордица
Төлөөлөгч

СУУРИН БУС ГИШҮҮД

ОУАЭА



Рафаэль Мариано Гросси

Ерөнхий захирал

ОУХБ



Клэр Куртейл-Мулдер

БНХАУ, Монгол Улсыг хариуцсан захирал

ОУШХБ



Жузеппе Крокетти

БНХАУ, Монгол Улсыг Хариуцсан төлөөлөгчийн газрын дарга

ЮНЕСКО



Шахбаз хаан

Бээжин дэх ЮНЕСКО-гийн газрын захирал, төлөөлөгч

НҮБ-ын БОХ



Какуко Нагатани-Ёшида

Химийн бодис, хог хаягдал, агаарын чанар хариуцсан Бангкок дахь бүсийн зохицуулагч

ЮНИДО



Тонилин Лим

БНХАУ-ын Бээжин хот дахь Бүсийн газрын төлөөлөгч, дарга

НҮБ - Хүний суурьшлын хөтөлбөр



Лаксман Перера

Япон дахь салбарын Хүний суурьшлын асуудал хариуцсан мэргэжилтэн

МОНГОЛ ДАХЬ НҮБ-ЫН ГОЛ ТҮНШҮҮД

2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд бид хэрхэн түншилж, хамтран ажиллаж байна гэдэг юу юунаас ч илүүтэй чухал болоод байна. Өөрөөр хэлбэл хөгжлийн төлөөх ажил хэргийг явуулахдаа зарчим болон нотолгоонд суурилах нь дэлхий дахинд төдийгүй Монгол Улсын хувьд их чухал юм. 2020 онд Монгол дахь НҮБ нь Монгол Улсын Засгийн газар, тус улсын хөгжлийн олон талт түншүүдтэй бат бөх түншлэлийн харилцаагаа үргэлжлүүлэн хөгжүүлж ирлээ.

Монгол дахь НҮБ КОВИД-19 цар тахлын үед ч тогтвортой хөгжлийг амжилтанд хүргэхийг зорьж буй Засгийн газрын манлайллыг сайшаан хүлээн авч, талархаж байна. Бидэнтэй нягт хамтран ажилладаг Засгийн газрын түнш байгууллагуудыг Зураг 1-т жагсаав.

Нэмж дурдахад, НҮБ энэхүү тайланд дурдсан үр дүнг иргэний нийгэм, их дээд сургууль, эрдэм шинжилгээний, олон талт хамтын ажиллагааны болон төр, засгийн байгууллагуудыг төлөөлсөн хэрэгжүүлэгч түншүүдийнхээ дэмжлэггүйгээр ханган биелүүлэх боломжгүй байсан. Бид, та бүхэнд бүгдэд нь талархаж байна. Тогтвортой хөгжлийн түншлэлээ үргэлжлүүлж, хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлэхийн

төлөө ажиллахдаа бид таатай байх болно. Бидэнтэй хамтран ажиллаж ирсэн төрийн бус байгууллагууд (ТББ), их дээд сургууль, эрдэм шинжилгээний болон олон талт хамтын ажиллагааны байгууллагууд, бусад улс орны Засгийн газрын түнш байгууллагуудыг Зураг 2-т жагсаав.

НҮБ нь олон талт болон хоёр талт хөгжлийн түншүүд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд бидний хэрэгжүүлсэн хүмүүнлэгийн болон хөгжлийн хөтөлбөрт санхүүжилтийн үнэлж баршгүй дэмжлэг үзүүлж ирснийг сайшаан, гүнээ талархаж байна. Бидэнд санхүүгийн дэмжлэг үзүүлж хамтран ажилласан санхүүжүүлэгч байгууллагуудыг Зураг 3-т жагсаав.

Санхүүжилтээс гадна, Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банк (АХБ), Европын Холбоо (ЕХ)-той бат бөх түншлэлийн харилцаагаа хэвээр хадгалж, улам бүр хөгжүүлж ирлээ. Үүний үр дүнд, санхүүгийн болон техникийн тусламж хоорондын уялдааг сайжруулж, Монгол улсад үзүүлэх дэмжлэг илүү үр дүнтэй болов. 2020 онд ЕХ НҮБ болон хөгжлийн түншүүдтэй хамтран Монгол дахь хөгжлийн тусламж, хамтын ажиллагааг сайжруулах бүтцийн үйл явцыг эхлүүлсэн. Уг үйл явц 2021 оноос үр өгөөжөө өгч эхэлнэ хэмээн бид найдаж байна.

Зураг 1: НҮБ-тай хамтран ажилласан төрийн байгууллагууд

Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч түнш байгууллагууд	
1	УИХ-ын Тамгын газар
2	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
3	Шадар сайдын ажлын алба
4	Гадаад харилцааны яам
5	Барилга, хот байгуулалтын яам
6	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
7	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
8	Сангийн яам
9	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
10	Эрүүл мэндийн яам
11	Хууль зүй, дотоод хэргийн яам
12	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
13	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
14	Зам, тээвэр хөгжлийн яам
15	Хүний эрхийн үндэсний комисс
16	Үндэсний статистикийн хороо
17	Төрийн албаны зөвлөл
18	Онцгой байдлын ерөнхий газар
19	Үндэсний хөгжлийн газар
20	Жендэрийн үндэсний хороо
21	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
22	Стандарт, хэмжил зүйн газар
23	Цаг уур, орчны шинжилгээний газар
24	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
25	Эх, нялхсын эрүүл мэндийн үндэсний төв
26	Хавдар судлалын үндэсний төв
27	Улсын нэгдүгээр төв эмнэлэг
28	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
29	Улсын мал эмнэлгийн төв лаборатори
30	Орон нутгийн засаг захиргаа
31	Улаанбаатар хотын захиргаа
32	Нийслэлийн шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацийн газар
33	Дархан хотын Засаг даргын Тамгын газар
34	Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар
35	Орхон аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар

Зураг 2: Монгол дахь НҮБ-ын удирдлагын баг, хамт олны түншилж ажилласан үндэсний болон олон улсын төрийн бус байгууллагууд, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд, олон талт хамтын ажиллагааны байгууллагууд, бусад улс орны Засгийн газрын байгууллагууд

Үндэсний ТББ-ууд

- 1 Банкируудын холбоо
- 2 Иргэний боловсролын төв
- 3 Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо
- 4 Эмэгтэйчүүдийн үндэсний сүлжээ
- 5 Ойн нөхөрлөл
- 6 Гэр хорооллын зураглал төв
- 7 Жендэрийн тэгш байдал төв
- 8 Монголын ажил олгогчдын холбоо
- 9 Монголын хүүхдийн өвчин судлалын төв
- 10 Монголын улаан загалмай нийгэмлэг
- 11 Шинэ нийгмийн эрүүл мэнд
- 12 Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд

Олон улсын ТББ-ууд

- 1 Адвентист хөгжил ба тусламжийн агентлаг
- 2 Алтны бичил уурхайн зөвлөл
- 3 Азийн сан
- 4 Хүүхдийн биеэ үнэлэлт, худалдаалах гэмт хэргийг таслан зогсооё
- 5 Үр удмын сан
- 6 Олон улсын аврах хороо
- 7 Мерси Корпс
- 8 Норвегийн дүрвэгчдийн зөвлөл
- 9 ПИН
- 10 Улаан загалмай нийгэмлэг
- 11 Хүүхэд хамгаалах сан
- 12 Дэлхийн зөн

Их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд

- 1 Ургамал, газар тариалангийн хүрээлэн
- 2 Мал эмнэлгийн хүрээлэн
- 3 Хөдөө аж ахуйн их сургууль
- 4 Маастрикийн их сургууль - НҮБ-ын Их Сургууль Мэрит
- 5 МУИС-ийн Цөмийн судалгааны төв
- 6 Монгол Улсын их сургууль
- 7 Анагаахын шинжлэх ухааны их сургууль
- 8 Стокгольмын байгаль орчны институт

Олон талт/гадаад орны ЗГ-ын байгууллага

- 1 Азийн хөгжлийн банк
- 2 Даян дэлхийн ногоон хөгжлийн институт
- 3 Улс орны Засгийн газрууд
- 4 Швейцарын эдийн засгийн яам

Зураг 3: Монгол дахь НҮБ-ын удирдлагын баг, хамт олонд санхүүгийн дэмжлэг үзүүлж ажилласан санхүүжүүлэгч байгууллагууд

Улс орон/Засгийн газрын байгууллагууд

- | | |
|---|---|
| 1 Австралийн олон улсын хөгжлийн агентлаг | 11 Шведийн олон улсын хөгжлийн агентлаг |
| 2 Австралийн Гадаад харилцаа, худалдааны яам | 12 Швейцарын хөгжлийн агентлаг |
| 3 Английн Олон улсын хөгжлийн яам | 13 Канад Улсын Засгийн газар |
| 4 Европын Комисс | 14 Дани Улсын Засгийн газар |
| 5 ГАВИ вакцины эвсэл | 15 Япон Улсын Засгийн газар |
| 6 Олон улсын уур амьсгалын санаачилга | 16 Люксембургын Их Гүнт Улсын Засгийн Газар |
| 7 Европын Комиссын Олон улсын хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага | 17 Монако Улсын Засгийн газар |
| 8 АНУ-ын Гадаад хэргийн яамны хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх алба | 18 Нидерланд Улсын Засгийн газар |
| 9 БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг | 19 БНСУ-ын Засгийн газар |
| 10 Шведийн Байгаль орчныг хамгаалах агентлаг | 20 Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс |
| | 21 АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг |

Глобал төрөлжсөн сангууд

- | | | | |
|----|---|----|---|
| 1 | Дасан зохицлын сан | 15 | Монреал протоколыг хэрэгжүүлэгч олон талт сан |
| 2 | Онцгой байдлын хариу арга хэмжээний төв сан | 16 | Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн түншлэл - УАӨҮАСБ |
| 3 | Европын ардчилал, хүний эрхийн сан | 17 | Ногоон эдийн засгийн төлөөх түншлэлийн Олон талт итгэлцлийн сан |
| 4 | Даян дэлхийн боловсролын сан | 18 | Ядуурал-Байгаль орчны санаачилгын сан |
| 5 | Даян дэлхийн байгаль орчны сан | 19 | Техникийн хамтын ажиллагааны байнгын хөтөлбөр |
| 6 | Даян дэлхийн жендэрийн сан | 20 | Олон улсын химийн бодисын менежментийн стратегийн арга |
| 7 | Даян дэлхийн эрүүл мэндийн сан | 21 | Тогтвортой хөгжлийн зорилтууд - Сан |
| 8 | Даян дэлхийн хүнсний шим тэжээлийн сан | 22 | Хүүхдийн эсрэг хүчирхийллийг цэглэх сан |
| 9 | Боловсролын төлөөх даян дэлхийн түншлэл | 23 | НҮБ-ын КОВИД-19 ОТТИС |
| 10 | Даян дэлхийн хүүхэд хамгаалах сан | 24 | НҮБ-ын Ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах хөтөлбөр ба Олон талт түншүүдийн итгэлцлийн сан |
| 11 | Даян дэлхийн нийгмийн хүртээмжийн сан | 25 | НҮБХХ Биологийн олон янз байдлыг санхүүжүүлэх итгэлцлийн сан |
| 12 | Даян дэлхийн ус, ариун цэвэр, эрүүл ахуйн сан | | |
| 13 | Уур амьсгалын ногоон сан | | |
| 14 | БНСУ-ын Олон улсын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний сан | | |

ТББ-ууд

- | | |
|---|---|
| 1 | НҮБ-ын Хүүхдийн сангийн Канад дахь Үндэсний хороо |
| 2 | БНСУ-ын хүүхдийн сан |
| 3 | НҮБ-ын Хүүхдийн сангийн Итали дахь Үндэсний хороо |
| 4 | НҮБ-ын Хүүхдийн сангийн Япон дахь Үндэсний хороо |
| 5 | Япон улсын сайн дурын хандив |
| 6 | НҮБ-ын Хүүхдийн сангийн БНСУ дахь Үндэсний хороо |
| 7 | НҮБ-ын Хүүхдийн сангийн Саудын Араб дахь Үндэсний хороо |
| 8 | НҮБ-ын Хүүхдийн сангийн Швед дэх Үндэсний хороо |
| 9 | НҮБ-ын Хүүхдийн сангийн Англи дахь Үндэсний хороо |

Хувийн салбар

- | | |
|---|---|
| 1 | Билл ба Мелинда Гэйтсийн сан |
| 2 | Говь Оюу хөгжлийг дэмжих сан |
| 3 | Оюу толгой компани |
| 4 | Хувийн салбарын санхүүжилт босголт – нэгдсэн нөөц сан |

Олон улсын санхүүгийн байгууллага

- | | |
|---|---------------------|
| 1 | Азийн хөгжлийн банк |
|---|---------------------|

1

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН ЧИГ
ХАНДЛАГА


Гэрэл зургийг Э. Батзаяа/ХХААБ

НҮБ нь Монгол хүний сайн сайхан амьдралын төлөө хувь нэмрээ оруулж байна.

2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр батлагдсан цагаас эхлэн Монгол Улс уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлд дорвитой алхам хийж ирсэн. Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн гол зарчмуудыг тусгасан урт, дунд хугацааны хэд хэдэн бодлого, хөтөлбөр боловсруулж, ТХЗ-уудын хэрэгжилтэд хяналт тавих институцийн механизмыг бүрдүүлээд байна. НҮБ-ын Ерөнхий ассамблей 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг баталсны дараа 2016 оноос хойш хэрэгжүүлж ирсэн Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-ийг орлох “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг Монгол Улсын Их хурал 2020 оны 5-р сард батлаад байна.

КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй эрүүл мэнд, нийгэм-эдийн засгийн нөлөөлөл, мөн Монголын улс төрд гарсан өөрчлөлт зэрэг нь 2020 оныг Монгол улсын хөгжлийн үйл явцад нөлөөлөх онцгой жил болгож байна. Монгол Улс 2020 оны 11-р сарын дунд үе хүртэл дотооддоо халдвар тархаалгүй тогтоон барьж, КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах чиглэлээр амжилттай ажиллаж ирсэн цөөхөн орны нэг байв. Гэхдээ, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг эрт хэрэгжүүлж, 2020 оны 3-р сараас улсын хилээ бүрэн хаасан зэрэг нь тус улсын нийгэм-эдийн засгийн нөхцөл байдалд ихээхэн хүндрэл учруулаад байна.

Зураг 4: ДНБ-ний салбарын бүтэц, 2020 оны бууралт



Эх сурвалж: ҮСХ, 2021 оны 2-р сар

Монгол Улс 90-ээд оны эхээр ардчилсан орон болсноос хойших 7 дахь удаагийн УИХ-ын сонгууль 2020 оны 6-р сард явагдаж, засгийн эрхийг барьж байсан (2016 оноос хойш засгийн эрхийг барьж байсан) улс төрийн нам уг сонгуульд ялснаар, 2020 оны 7-р сард шинэ Засгийн газраа байгуулсан. Гэхдээ, Засгийн газар 6 сарын дараа огцорсон. Шинэ Засгийн газар хөгжлийн дараах дөрвөн тэргүүлэх чиглэлийг дэвшүүлээд байна. Үүнд: 1) Цар тахлыг даван туулах, 2) Эдийн засгийг сэргээх, 3) Дундаж давхаргыг дэмжих үндэсний шинэ тогтолцоо бий болгох, 4) Шударга ёсыг бэхжүүлж, цахим засаглалыг хөгжүүлэх. Гэсэн хэдий ч бүтцийн сул талууд оршсон хэвээр байгаа бөгөөд энэ нь ТХЗ-г хангахад чиглэсэн ахиц дэвшил гаргахад саад тотгор учруулж байна.

Урьдчилан тооцоолсноор, 2020 онд Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2019 онтой харьцуулахад 5.3 хувиар буурах төлөвтэй байна¹. Зураг 4-т үзүүлсэнчлэн, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрлэл, аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбарын бууралт эдийн засгийн өсөлт саарахад хамгийн ихээр нөлөөлжээ.

Монгол Улсын эдийн засаг өнөө хэр олборлох салбараас ихээхэн хамааралтай, гаднын нөлөөнд туйлын өртөмтгий хэвээр байна. КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор хөл хорио тогтоосноос үүдэлтэй нөлөөллөөс гадна

уул уурхайн салбарын өсөлт буурсан нь аж үйлдвэрийн бусад салбар болон үйлчилгээний салбарын өсөлт буурахад нөлөөлжээ.

Цаашлаад цар тахал боловсрол болон эрүүл мэндийн салбарт асар их сөрөг нөлөө үзүүлээд байна. КОВИД-19 цар тахлын улмаас танхимын сургалтыг теле/радио хичээл, цахим сургалтад шилжүүлснээр боловсролын ялгаа улам бүр дордов. НҮБ-ын Хүүхдийн сангийн MICS Plus мэдээллийн сангийн мэдээллээр, хот суурин газрын нийт өрхийн 22 хувь, хөдөө орон нутаг дахь нийт өрхийн 44 хувь нь интернетэд холбогдоогүй байна.

Цар тахал 2020 онд боловсролын хүртээмж буюу хүүхдийн боловсролд хамрагдалтын төвшинд ихээхэн нөлөөлсөн бөгөөд хөдөө орон нутаг дахь дөрвөн хүүхэд тутмын нэг, хот суурин газрын гурван хүүхэд тутмын нэг нь теле/радио хичээлд хамрагдаж чадаагүй бол хот, хөдөөгийн нийт хүүхдүүдийн дөнгөж тал хувь нь нэмэлт цахим хичээлд хамрагдаж чадсан байв. Түүгээр ч зогсохгүй, хувийн сургуулиудын санал болгосон нэмэлт хичээл улсын сургуулийнхтай харьцуулахад даруй хоёр дахин илүү байсан байна². Энэ нь боловсролын салбар дахь нэгэнт илэрхий тэгш бус байдлыг даамжруулахад зогсохгүй, орлого, баялгийн тэгш бус байдал КОВИД-19 хямралаас үүдэн ужгирах хандлагатай болж ирэхэд нөлөөллөө³.

¹ ҮСХ, 2021

² MICS Plus, Үндэсний статистикийн хороо болон НҮБ-ын Хүүхдийн сан, 2020

³ НҮБХХ-ийн Хүний хөгжлийн тайланд дурдсанаар, Монгол Улсын боловсролын тэгш бус байдлын коэффициент 2019 онд 11.9 хувтай гарсан нь Төв азийн зэргэлдээ улс орнуудтай харьцуулахад хамаагүй өндөр хувь юм.

КОВИД-19 цар тахал нь онцгой байдлын үеийн бэлэн байдлыг хангах, үйлчилгээг нийт иргэд, түүний дотор цар тахлын нөлөөнд хамгийн ихээр өртсөн болон өнөөгийн тогтолцооноос орхигдож ирсэн иргэдэд тэгш хүртээмжтэй болгох чиглэлд эрүүл мэндийн салбарыг шинэчлэх шаардлагатай байгааг тод томруун харуулж өглөө. Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим (МҮХАҮТ) КОВИД-19-ийн дэгдэлт эхэлснээс хойш ойролцоогоор 8000 ажлын байр байхгүй болсон талаар мэдээлэв. Уг чиг хандлага ажилгүйдлийн төвшинг улам бүр нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах чиглэлээр олсон ахиц дэвшлийг үгүй хийхэд нэрмээс болж байна. Энэ бүгд Засгийн газарт ирэх дарамт шахалтыг ч нэмэгдүүлж байна.

2018 онд ядуурлын төвшин 28.4 хувьтай байснаас үзвэл, бараг 905 мянган иргэд ядуурлын шугамаас доогуур төвшинд амьдарч байна. Үүнээс гадна, нийт хүн амын 14.9 хувь (өөрөөр хэлбэл 474.8 мянган хүн) нь ядуурлын шугамаас дөнгөж дээгүүрхэн⁴ амьдардаг бөгөөд гэнэтийн цочрол тохиох үед, эдгээр эмзэг өрхүүд ядуурал руу хялбархан гулсаж орно гэсэн үг. 2018 оны байдлаар гэхэд, Монгол Улсын хүн амын 7.3 хувь нь (өөрөөр хэлбэл 230 мянган хүн) олон хэмжээст ядууралд өртсөн байсан бол 15.5 хувь нь (өөрөөр хэлбэл 492 мянган хүн) олон хэмжээст ядууралд өртөж болзошгүй гэсэн ангилалд багтсан байв.

КОВИД-19 цар тахлын үед Засгийн газар эмзэг бүлгийн өрхүүдийг хамгаалах зорилгоор хүүхдийн мөнгөний хэмжээг нэмэгдүүлэх, хүнсний талон олгох хөтөлбөр хэрэгжүүлэх, нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх зэрэг дорвитой хэд хэдэн арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. АХБ-ны

хийсэн судалгаанаас харвал, Засгийн газраас энэ чиглэлээр арга хэмжээ аваагүй бол, 2018 онд 28.4 хувьтай байсан ядуурлын төвшин 2020 онд 36.7 хувь болж нэмэгдэх байв. Уг судалгаа нийгмийн хамгааллын чиглэлээр авсан арга хэмжээ нь 2020 онд ядуурлын төвшин 17.6 хувь хүртэл буурахад дөхөм үзүүлсэн гэж үзсэн байна. Үүний зэрэгцээ НҮБ-ын хийсэн судалгаа КОВИД-19 хямралын улмаас ядуурлын төвшин нэмэгдэх хандлагатай байгааг анхааруулаад байна⁵.

Хүний хөгжлийн индекс (ХХИ)-ээр Монгол Улс 2019 онд дэлхийн 189 улс орноос 99-т жагсаж⁶ 0.737 гэсэн үнэлгээтэй байсан нь Монгол Улсыг хүний хөгжлөөр өндөр төвшний орнуудын ангилалд оруулсан. Гэсэн хэдий ч, уг үзүүлэлтийг тэгш бус байдлын утгад шилжүүлбэл, хүний хөгжлийн тэгш бус байдлаар засварласан ХХИ 0.634 болж, даруй 14.0 хувиар буурна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын хүний тэгш бус байдлын коэффициент 14.0 хувьтай тэнцэж байна.

Монгол дахь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо хязгаарлагдмал хэвээр байгаа бөгөөд одоогоор Улсын Их Хурлын нийт 76 суудлын 13-ыг (17%) эмэгтэйчүүд эзэлж байна. КОВИД-19 цар тахлын хөл хорионы үеэр эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийлэл нэмэгдэх хандлага ажиглагдсан. Цар тахлын сөрөг үр дагавар нь хүүхэд, эмэгтэйчүүд, охид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, залуучууд, үндэсний цөөнх, гэр хорооллын оршин суугчид, албан бус салбарт ажиллагсад, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид, мухардмал байдалд орсон иргэд, бүртгэлгүй оршин суугчдад гүн гүнзгий нөлөөлж, тэдгээрийн улс орныхоо тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулахад саад болж байна.

⁴ 2018 Ядуурлын талаарх шинэчилсэн мэдээ, Дэлхийн банк болон Үндэсний статистикийн хороо

⁵ Монгол Улсын CGE загвар, WEFM-е, ESCAP Excel-суурьтай загвар

⁶ Хүний хөгжлийн тайлан, 2020, НҮБХХ; <http://hdr.undp.org/sites/default/files/Country-Profiles/MNG.pdf>

2

НҮБ-ААС ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ҮЗҮҮЛСЭН ДЭМЖЛЭГ

2.1 ЕРӨНХИЙ ТОЙМ

2020 он 2017-2021 оны НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээ (НҮБ-ЫН ХТХ)-ний хэрэгжилтийн дөрөв дэх жил байсан бөгөөд КОВИД-19-ийн хариу арга хэмжээнд НҮБ-ын үйл ажиллагаа тэргүүлэх ач холбогдол өгөх шаардлагын үүднээс НҮБ-ын ХТХ-ний Удирдах зөвлөлтэй тохиролцсоны дагуу ХТХ-г хэрэгжүүлэх хугацааг нэг жилээр сунгаад байна.


НҮБ-ын системийн байгууллагууд 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, энэ хүрээнд, 17 ТХЗ-оос 16-г нь хангахад Монгол Улсад дэмжлэг үзүүлэх чиглэл баримтлан стратегийн хийгээд үндсэн нэгжийн төвшинд ажиллаж ирлээ. ТХЗ-14 (далай, тэнгисийн нөөцийг хамгаалах) нь Монгол Улсын хувьд анхаарах асуудлын тоонд орохгүй бөгөөд харин гол мөрөн, нуур, булаг шанд зэрэг усны экосистемийг хамгаалах зорилтууд ТХЗ-6 болон ТХЗ-15-д агуулагдсан болно.

2017-2021 оны хооронд НҮБ нийт дүнгээрээ 163 сая ам. долларын хөрөнгө татан төвлөрүүлсний


105 сая ам. долларыг 21 аймаг, нийслэл хотыг хамарсан нийт 174 төсөл, хөтөлбөрийг 71 хэрэгжүүлэгч түнш байгууллагатай хамтран хэрэгжүүлэхэд зориулж зарцуулаад байна. Эдгээрээс 140 нь улсын хэмжээнд нөлөөлөл үзүүлсэн төсөл, хөтөлбөр байв. Эдгээр арга хэмжээ нь 16 ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдлээ. Зураг 6-д үзүүлсэнчлэн, НҮБ-ын оролцооны тэн хагас нь 5 ТХЗ-ыг хэрэгжүүлэх хүрээнд Монголчуудын сайн сайхан аж байдлыг дээшлүүлэх, нэр төрөө эрхэмлэн өндөрт өргөж явахад нь дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн болно.

НҮБ-ын үйл ажиллагааны 23 хувь нь эх дэлхийгээ хамгаалахтай холбоотой ТХЗ-уудын хүрээнд Монголын үзэсгэлэнт байгаль, эх нутгийг хамгаалахад, 14 хувь нь Монголын хөгжил цэцэглэлтэд, 7 болон 6 хувь нь Монгол Улсад тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд энх тайван, шударга ёс, түншлэлийг дэмжихэд тус тус зориулагдлаа.

Зураг 5: Монгол дахь НҮБ-ын дэмжлэгтэй хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн газар зүйн байршил




Зураг 6: НҮБ-аас 5 П-ийн хүрээнд ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд зориулж үзүүлсэн 105 сая долларын дэмжлэг



Хандивлагчид болон хэрэгжүүлэгч түншүүдийн үнэтэй хувь нэмэр, түншлэл нь НҮБ-д эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх боломжийг олгосон юм. 2017-2021 оны хооронд Монгол дахь НҮБ нь Монгол Улсад 16 ТХЗ-ыг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Засгийн газрын 35 байгууллага, 12 ТББ, 12 ОУ-ын ТББ, 8 их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, 4 олон талт хамтын ажиллагааны байгууллагуудтай нягт хамтран ажиллав. НҮБ нийт төсөл, хөтөлбөрийнхөө 88 хувийг төр, засгийн түнш байгууллагуудтай, 8 хувийг иргэний нийгмийн байгууллага, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газар НҮБ-тай хамтран ажиллах хүсэл эрмэлзэлтэйгээ нотлон, хамтын санхүүжилттэй үйл ажиллагаанд дахь өөрийн оролцоог аажмаар нэмэгдүүлж, өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд гэхэд ойролцоогоор хамтын санхүүжилттэй үйл ажиллагаанд 10 сая ам. долларын санхүүжилт хийгээд байна. Өнөөг хүртэлх хугацаанд НҮБ-ын төсөл, хөтөлбөрүүдийг 25 глобал төрөлжсөн сангууд, бусад улс орны Засгийн газрын 22 байгууллагууд, 9 ТББ, хувийн хэвшлийн 4 байгууллага дэмжин ажиллалаа.

Зураг 7: НҮБ-ын төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэгч түнш байгууллагуудын төрөл




НҮБ-ын бүхий л үйл ажиллагааг 1) хүртээмжтэй өсөлт, байгалийн нөөцийн тогтвортой менежментийг дэмжих; 2) нийгмийн хамгааллыг сайжруулах, чанартай, тэгш, хүртээмжтэй нийгмийн үйлчилгээг бий болгох; 3) олон нийтийн оролцоог дэмжиж, хариуцлагыг дээшлүүлэх гэсэн гурван үр дүнгийн чиглэлд хуваан ангилдаг.

Үр дүн чиглэл 1-ийн хүрээнд, НҮБ хүлэмжийн хийн (ХХ) ялгарлыг бууруулах, тусгай хамгаалалттай ойт газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх, ДНБ-д эзлэх нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, зохистой ажлын

байрыг хөхүүлэн дэмжих, гамшгаас үүдэлтэй эдийн засгийн алдагдлыг бууруулах, ядуурлыг бууруулахад (ялангуяа хүүхдийн ядуурлыг) хувь нэмрээ оруулж ажиллалаа.


Зураг 8: Үр дүнгийн чиглэл 1-ийн шалгуур үзүүлэлтүүдийн төлөв



Үр дүнгийн чиглэл 2-ийн хүрээнд, НҮБ ус, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн ерөнхий боловсролын сургуульд хамрагдах төвшинг нэмэгдүүлэх, амьжиргааны төвшнөөр хүн амын доод 20 хувьд хамаарах өрхийн 5-аас доош насны хэвийн өсч бойжиж буй хүүхдийн тоог нэмэгдүүлэх, 4, 8-р ангийн сурагчдын математик, байгалийн шинжлэх ухааны хичээлийн сурлагын амжилтын төвшинг дээшлүүлэх, 40-өөс дээш


насны хүн амын цусны даралт ихсэх, чихрийн шижин өвчний шинжилгээнд хамрагдах хувийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах чиглэлээр ажиллалаа. Гэсэн хэдий ч, жирэмсний хугацаанд жирэмсний хяналтад 6-аас доошгүй удаа хамрагдсан эмэгтэйчүүдийн эзлэх хувь, амьжиргааны төвшнөөр хамгийн доод 20 хувьд хамаарах өрхийн 36-39 сартай хүүхдийн цэцэрлэгт хамрагдалт буурсан дүнтэй гарлаа.

Зураг 9: Үр дүнгийн чиглэл 2-ын шалгуур үзүүлэлтүүдийн төлөв



Үр дүнгийн чиглэл 3-ийн хүрээнд НҮБ-аас Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (ЭАБХУТК), ОУХБ-ын Хөдөлмөрийн тухай конвенц зэрэг олон улсын гэрээ, конвенцуудыг Монгол Улсад хэрэгжүүлэх, түүнчлэн Хүний эрхийн хэрэгжилтийг хянах нийтлэг механизм (ХЭХХНМ) зэрэг холбогдох гэрээ, конвенцын хяналтын байгууллагуудын гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлээд байна. НҮБ-аас Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль зэрэг хуулийг шинэчлэн найруулахад дэмжлэг үзүүлсэн болно.

Зураг 10: Үр дүнгийн чиглэл 3-ийн шалгуур үзүүлэлтүүдийн төлөв




НҮБ нь чадавхыг бэхжүүлэх, техникийн туслалцаа үзүүлэх, бодлогын зөвлөгөө өгөх, манлайлал, мэдлэг хуваалцах, түншлэл, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, шууд дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх зэрэг үйл ажиллагаагаар дамжуулан Зураг 8, 9, 10-т нарийвчлан тодорхойлсон үр дүнгийн төвшний үзүүлэлтүүдээр хэмжигддэг Монгол Улсын ололт амжилтад хувь нэмэр оруулж


ажиллалаа. НҮБ-ын үйл ажиллагааны 92 хувь нь хүний эрхийг сурталчлан таниулах, хамгаалахад чиглэгдсэн бөгөөд 94 хувь нь жендэрийн эрх тэгш байдлыг хангахад дэмжлэг үзүүлэхэд чиглэгджээ.

НҮБ мөн, Зураг 12-т үзүүлсэнчлэн олон улсын хүний эрхийн гэрээг амжилттай хэрэгжүүлэхэд нь Засгийн газарт дэмжлэг үзүүлж байна.

Зураг 11: НҮБ-аас Монгол Улсын Засгийн газарт үзүүлсэн дэмжлэгийн төрөл



Зураг 12: НҮБ-аас Хүний эрхийн олон улсын гэрээг хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газарт үзүүлсэн дэмжлэг



КОВИД-19 цар тахал 2020 оны туршид эдийн засаг, улс төр, нийгмийн амьдралыг ихээхэн хэмжээгээр тасалдуулаад байна. Монгол Улсын Засгийн газар, түүний хөгжлийн түншүүд, үүний дотор НҮБ өөрсдийн нөөцийг бусад урт хугацааны хөгжлийн санаачилгуудыг хойш тавих замаар КОВИД-19-өөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад зориулан зарцуулжээ. НҮБ-аас Нийгэм, эдийн засгийн хариу арга хэмжээний төлөвлөгөө (НЭЗХАХТ)-ий 5 тулгуур баганын хүрээнд 27.4 сая ам. долларын санхүүжилт татан төвлөрүүлсний 13.2 сая ам. долларыг КОВИД-19-ийн нийгэм, эдийн засагт үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах хариу арга хэмжээ, эрүүл мэнд, иргэдийг хамгаалах, эдийн засгийн хариу арга хэмжээ авах, сэргээх, микро эдийн засгийн хариу арга хэмжээ ба олон талт хамтын ажиллагаа, нийгмийн эв нэгдэл, нягтрал ба олон нийтийн хүндрэлийг даван туулах чадварыг дээшлүүлэх зэрэгт зориулж зарцуулаад байна. Үүний сацуу, НҮБ өөрийн татан төвлөрүүлсэн 3.7 сая ам. долларыг хахир өвөл болон КОВИД-19-ийн хариу арга хэмжээ болгон хүмүүнлэгийн тусламж үзүүлэхэд зориулж зарцуулав.

Монгол дахь НҮБ-ын системийн байгууллагуудын үр дүнтэй хамтын ажиллагаа энэхүү тайланд дурдагдсан бүхий л ололт амжилтад хүрэхэд чухал үүрэг гүйцэтгэв. Иргэддээ илүү үр дүнтэй үйлчлэх боломж олгоход чиглэсэн Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааг дэмжих зорилготой хамтарсан хөтөлбөр, төслүүдийг төлөвлөж, хэрэгжүүлж, хяналт тавихын тулд НҮБ-ын системийн байгууллагууд өөрсдийн хүч нөөцөө төрөл бүрийн чиглэлийн бүлэг, үр дүнгийн бүлгүүдэд хуваан зохион байгуулж ажиллалаа. Энэхүү сайжруулсан зохион байгуулалт нь Монгол Улсын ТХЗ-уудыг амжилтад хүргэхэд чиглэсэн хөгжлийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн хамтарсан мэдээлэл харилцаа, нөлөөллийн арга хэмжээ авах, үйл ажиллагааны өргөжилтийн үр өгөөжийг дээшлүүлж, зардлыг бууруулах зорилго бүхий Нийтлэг үйл ажиллагааны стратеги хэрэгжүүлэх зэрэг хичээл зүтгэлийг мөн багтаасан болно. Үүнээс гадна, НҮБ-аас нэгдсэн бодлогын зөвлөгөө өгөх замаар Засгийн газарт дэмжлэг үзүүлэх чиглэлд нягт хамтран ажиллалаа.



Хувиараа аж ахуйн эрхлэгч Мөнгөнчимэг

Эцэст нь тэмдэглэхэд, НҮБ-ын Монгол дахь үйл ажиллагаанд урьд өмнө тохиож байгаагүй КОВИД-19 цар тахлаас үүдсэн үйл ажиллагааны гадаад орчин нөлөөлж байна. Цар тахлын улмаас жилийн ихэнх хугацаанд олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахад хязгаарлагдмал байсан нь биечлэн хийхээр төлөвлөсөн чадавхжуулах үйл ажиллагаа зэрэг хөгжлийн зарим арга хэмжээнд саад учруулж ирсэний сацуу хязгаарлалт-ын арга хэмжээ нь нэгэнт оршсоор ирсэн жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ), хүүхдийн эсрэг хүчирхийлэл (ХЭХ), ажилгүйдэл, ядуурал зэрэг нийгэм, эдийн засгийн хүндрэлүүдийг улам бүр гүнзгийрүүлж байна.

Үүний зэрэгцээ, саяхан болж өнгөрсөн орон нутгийн болон УИХ-ын сонгууль НҮБ-ын түнш байгууллагуудын шийдвэр гаргагчид болон асуудал хариуцсан ажилтнууд өөрчлөгдөхөд хүргэсэн. Улмаар хөгжлийн болон хүмүүнлэгийн тулгамдсан асуудлууд, ялангуяа жендэрт суурилсан хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх зэрэг эмзэг асуудлуудад анхаарал хандуулахын тулд, түнш байгууллагуудын шинээр томилогдсон ажилтнуудын нарийн мэдрэмжтэй байх чадвар болон чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн хүчин чармайлтаа дахин давтах шаардлага гарч байлаа.

2.2 НҮБ-ЫН ХТХ-НИЙ ҮР ДҮНГИЙН ЧИГЛЭЛ НЭГ : ХҮРТЭЭМЖТЭЙ ӨСӨЛТ, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТИЙГ ДЭМЖИХ




Өвөл тэжээл сайн бэлтгэсэн малчид өвлийг өнтэй давах боломжтой. Завхан аймгийн Асгат сумын малчид.

НҮБ нь Монгол Улсын хууль эрх зүй болон бодлогын орчин, институцийн тогтолцооны хүрээнд хүртээмжтэй, тогтвортой хөгжлийг хангахад техникийн туслалцаа үзүүлж ирлээ. НҮБ-ын системийн 14 байгууллага 50 хэрэгжүүлэгч түнштэйгээ хамтран хэрэгжүүлсэн 98 хөтөлбөрт зориулан 53.8 сая доллар зарцуулаа. Эдгээр зорилтот арга хэмжээ нь 18 аймаг, нийслэл Улаанбаатар хотыг хамарч хэрэгжив.

Нийт санхүүжилтийг ядууралгүй, өлсгөлөнгүй, эрүүл мэнд болон сайн сайхан аж байдал, жендэрийн тэгш байдал, ус, ариун цэврийн байгууламж, цэвэр эрчим хүч, зохистой ажлын байр, үйлдвэрлэл, дэд бүтэц, тэгш бус байдал, тогтвортой хотууд, хариуцлагатай хэрэглээ, уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах үйл ажиллагаа, хуурай газрын экосистем, түншлэлтэй холбоотой 15 ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд зориулж зарцуулаад байна.

Зураг 13: Үр дүнгийн чиглэл 1: 5П-ийн хүрээнд 15 ТХЗ-ыг хангахад чиглэсэн 53.8 сая ам. долларын зарцуулалт



2020 онд Монгол Улсын үндэсний хөгжлийн бодлого төлөвлөлт, төсөв зохиох эрх зүйн орчин мэдэгдэхүйц сайжирсан бөгөөд, НҮБ-аас өмнөх жилүүдэд хийж хэрэгжүүлсэн ажилдаа тулгуурлан цаашид ТХЗ-ын нэгдсэн бодлогын хүрээг үндэсний төвшинд бий болгоход анхаарлаа төвлөрүүлж ажиллав. НҮБ-ын дэмжлэгтэй боловсруулсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг шинэчлэн баталснаар Монгол Улс нотолгоонд суурилсан, үр дүнд чиглэсэн төлөвлөлт, төсөвлөлт, хяналт-шинжилгээ, тайлагнал, аудитын системээ бэхжүүлж чадлаа. Шинэчилсэн хуульд заасны дагуу үндэсний болон орон нутгийн хөгжлийн стратеги, бодлого, төлөвлөгөөг Алсын хараа-2050-тай уялдуулах явдал нь 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн

хөтөлбөрт тусгагдсан хүсэл зорилгодоо хүрэх явдлыг баталгаажуулах механизмыг бүрдүүлж өгөх юм.

Байгаль орчныг хамгаалах тухайд, Монгол Улс НҮБ-ын төслүүдээр дамжуулан хамгаалалттай газар нутгийн сүлжээг 4.99 сая га (4.82 сая га орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг, 0.17 сая га улсын тусгай хамгаалалттай газар нутаг)-аар өргөтгөөд байна. Энэ нь, Монгол Улсын нийт газар нутгийн хэмжээ (1,553,560 хавтгай дөрвөлжин км)-тай харьцуулахад тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 3.2 хувиар нэмэгдүүлсэн хэрэг бөгөөд НҮБ-ын ХТХ-нд тусгасан зорилтот төвшнөөс даруй 0.6%-иар өссөн үзүүлэлт юм.

2.2.1 Хөгжлийн алсын хараа, стратеги ба төлөвлөгөө

Ядуурлын хамгийн сүүлийн үеийн төвшинг Монгол Улсын Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ны 2018 оны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааг үндэслэн тооцсон болно. Монгол Улсын ядуурлын төвшин 2018 оны байдлаар 28.4 хувьтай (хотын ядуурал 27.2 хувь; хөдөөгийн ядуурал 30.8 хувь; хүүхдийн ядуурал 38.5 хувь) байв. Энэ нь 2016 оны ядуурлын төвшин 29.6 хувь байсантай харьцуулахад 1.2 нэгж хувиар буурсан үзүүлэлт юм. НҮБ-ын дэмжлэгтэй боловсруулсан олон хэмжээст ядуурлыг тооцох аргачлал (Олон хэмжээст ядуурлын индекс) болон уг судалгааг хийх техникийн ур чадвар зэрэгт үндэслэн ҮСХ-оос 2020 оны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааг явуулсан бөгөөд энэхүү судалгааны үр дүнд ядуурлын олон хэмжээст цогц дүр зургийг гаргаж ирэхээр төлөвлөөд байна. Судалгааны үр дүнг 2021 онд гаргаж танилцуулна.

Олон хэмжээст ядуурлын шинжилгээ үргэлжилж байгаа бөгөөд үүнд нийгмийн үзүүлэлтүүдийн түүвэр судалгааны өгөгдөл болон гачигдлын шинжилгээг ашиглан хүүхдийн ядуурлыг хэмжих ажил багтаж байна.


КОВИД-19-ийн нөхцөл байдлаас үүдэн бий болох сөрөг нөлөөлөл нь улсын хэмжээний ядуурлын төвшинг нэмэгдүүлж, ТХЗ-ийг хэрэгжүүлэх чиглэлээр олсон тогтвортой хөгжлийн ололт амжилтыг ухраах эрсдэлтэй. Сангийн яам (СЯ), Эрүүл мэндийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам ТХЗ-той уялдуулсан төсөв боловсруулах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн бөгөөд улсын төсөвт зарим салбарын ТХЗ-ын үзүүлэлтүүдийг тусгах замаар ТХЗ-г хангахад чиглэсэн хөтөлбөрүүдийг санхүүжилтээр тасралтгүй хангах нөхцөлийг бүрдүүлж ажиллалаа. Үүний зэрэгцээ, НҮБ-ын

дэмжлэгтэйгээр Улаанбаатар хот болон Завхан аймаг ТХЗ-ууд, Алсын хараа-2050 болон 5 жилийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн үндсэн чиглэлтэй уялдсан 5 жилийн хугацаатай орон нутгийн хөгжлийн үндсэн чиглэлээ (2021-2025) батлаад байна. Энэхүү ололтыг улам бүр бэхжүүлж, хүчин чармайлтаа үргэлжлүүлэхийн тулд, 2020 оны 4-р сард Сангийн яамтай Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж, ТХЗ-тай уялдсан, үр дүнд чиглэсэн, нэгдсэн санхүүжилт, ил тод байдал, тайлагналын асуудлаарх түншлэлийг баталгаажууллаа.

Цөм арга зүй ашиглан бий болгосон шинэ үйлчилгээгээр дамжуулан дотоодын шилжилт хөдөлгөөн, цэвэр эрчим хүчний хүртээмж, хүний эрүүлмэнд, шинжлэх ухааны боловсролын талаарх үндэсний өгөгдөл болон чадавх сайжирлаа. НҮБ нь Монгол Улсын Засгийн газартай нягт хамтран ажилласнаар, 2020 онд хөдөө орон нутагт 1600 гаруй шинэ ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлэх замаар улсын эдийн засгийг төрөлжүүлэх, тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулаад байна. Цаашилбал, НҮБ нь зохистой хөдөлмөр эрхлэлт, ноолуур, нэхмэл сүлжмэл, арьс шир, мах, сүү, хүнсний ногооны

нэмүү өртгийн сүлжээ, түүнчлэн технологи дамжуулалт, сургалт, инновацид анхаарал төвлөрүүлэх байдлаар уран бүтээлчдийн тасраад байсан нэмүү өртгийн сүлжээг сэргээх чиглэлээр дэмжлэг үзүүлж ажиллалаа.

НҮБ-ын дэмжлэгтэйгээр “КОВИД-ын дараах Монгол ямар харагдах вэ?” сэдэвт аян зохион байгуулсны үр дүнд КОВИД-19-ийн дараах Монгол Улсыг хөгжүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийн багцыг тодорхойлоод байна.



Хөшигний ард, COVID-19 эмэгтэй уран бүтээлчдэд үзүүлэх нөлөөллийн талаарх НҮБ-ын ЮНЕСКО-ийн зөвлөлдөх уулзалтад оролцсон уран бүтээлчийн бүтээл.

2.2.2. Уур амьсгалын өөрчлөлт ба түүнийг сааруулах

Монгол Улс нь НҮБ болон хөгжлийн бусад түншүүдийн дэмжлэгтэйгээр уур амьсгалын өөрчлөлт болон түүнийг сааруулах үр дүнтэй арга хэмжээ авах боломж бүрдүүлэхүйц баттай үндэс суурийг тавьсан бодлогын төвшний томоохон ахиц дэвшил гаргаж чадлаа. Хүлэмжийн хийн ялгарлыг 2019 онд анхлан 14 хувиар бууруулахаар тогтоосон байсныг 22,7 хувь болгож, Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг (ҮХТХН) ихээхэн хэмжээгээр нэмэгдүүлэхэд НҮБ тусалж ажиллав. Үүн дээр нэмээд, хэрэв нүүрстөрөгчийг ялгаж авах, хадгалах, хог хаягдлыг эрчим хүч болгох технологи ашиглах зэрэг нөхцөлт бууруулах арга хэмжээг хэрэгжүүлбэл Монгол Улс үндэсний хэмжээний хүлэмжийн хийн ялгаралтыг 27.2 хувиар бууруулж чадахаар байна.

НҮБ-ын дэмжлэгтэйгээр Монгол Улс хүлэмжийн хийг бууруулах хяналтын суурь төвшинг тогтоосон бөгөөд үүнийг хүлэмжийн хий болон хүлэмжийн хийн бус параметрууд, үзүүлэлтүүдийг бууруулах чиглэлд олж буй ахиц дэвшилд туйлбартай хяналт

тавьж, тайлагнах зорилгоор Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцод (НҮБУАӨК) хүргүүлсэн болно. Хүлэмжийн хийн бууралтыг хэмжих, тайлагнах, баталгаажуулах (MRV) аргачлал болон зааварчилга туршсаны эцэст батлаад байна (Сайдын 2020 оны 37 тоот тушаал).

Ой мод нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах шийдэл тул, 564.531 га ойг хариуцдаг 100 гаруй ойн нөхөрлөлийн гишүүдийг сургаж, техникийн болон ложистикийн дэмжлэг үзүүлж, нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах, биологийн олон янз байдлыг хамгаалах зорилт агуулсан ойн менежментийн 10 жилийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зөвлөгөө, зааварчилга өгч ажиллалаа. Говь, Хангайн үзэсгэлэнт газар нутгийн 45000 га заган болон тайгын ой модны алдагдал, доройтлын бууралтаас үүсэх ялгарлын хэмнэлт нь⁷ хүлэмжийн хийн ялгарлыг 3,040,800 tCO₂ экв (тонн тутамд ногдох нүүрстөрөгчийн давхар исэлтэй тэнцэхүйц)-аар бууруулаад байна.

⁷ Дараагийн 20 жилийн хугацаанд t CO₂.eq

Цаашлаад, Стокгольмын конвенцод нэгдсэн орны хувьд, хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор боловсруулсан Монгол Улсын өнөөгийн бодлогын дагуу Хог хаягдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, нээлттэй шатаах эх үүсвэрт зориулсан ВАТ/ВЕР⁸ нэвтрүүлэх замаар санхүүжилтийн механизм болон U-POP⁹ ялгаруулалтыг бууруулах хөшүүрэг

боловсруулж ашиглах зэргээр хог хаягдлын менежментийн шинэ үр ашигтай системийг бий болгоод байна. Түүнчлэн, алтны бичил уурхай, жижиг уурхайн салбарын нийлүүлэлтийн гинжин хэлхээнд мөнгөн усны хэрэглээг халахад түлхэц үзүүлж, үндэсний чадавхыг бэхжүүлээ.



Цөлжилт, газрын доройтлын улмаас малчид ихээхэн сорилт бэрхшээлтэй тулгарч байна.

2.2.3. Экосистемийн үйлчилгээ

Өнгөрсөн жилүүдэд НҮБ-ын дэмжлэгтэйгээр мал аж ахуй, газар тариалангийн томоохон газар нутаг дахь 40 сумыг хамарсан мах, сүү цагаан идээ, хүнсний ногооны нэмүү өртгийн сүлжээнд 2213 ажлын байр бий болголоо. Энэхүү хамтын хүчин чармайлтад 12,794 малчин, хүнсний ногоо тариалагч, 78 хүнсний үйлдвэрлэл эрхлэгч, мэргэжлийн холбоод, мөн төв, орон нутгийн засаг захиргаад зэрэг сонирхогч талууд оролцоод байна. 2020 онд, ойн салбарын 6 жижиг мод боловсруулах нэгж байгуулах замаар 120 шинэ ажлын байр бий болголоо. НҮБ нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж ирсэн бөгөөд байгалийн нөөц ашигласны үр дүнд бий болсон орлогыг ашиглан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зориулах төсвийг нэмэгдүүлсэн. Малчдын бүлгүүд сумдын засаг даргатай малынхаа тоо толгойг жил тутам 5%-иар бууруулах, иж бүрэн арга хэмжээний хүрээнд бэлчээрийн менежментийг сайжруулах гэрээ байгууллаа. 1306 малчин өрх сайн дурын үндсэн дээр 225 бүлэг байгуулан 611.3 мянган га газрын ачааллыг бууруулах үүрэг амлалт аван ажиллаж байна. Нутаг дэвсгэрт түшиглэсэн сум хөгжлийн

төлөвлөгөөг боловсруулж, экосистемийн үйлчилгээг сайжруулах, биологийн олон янз байдлыг хамгаалах хэрэгцээ шаардлагыг харгалзсан зүй зохистой газар ашиглалтын төлөвлөгөөг боловсруулаад байна. Биологийн олон янз байдалд нэн чухал газар нутгийн хэмжээ зорилтот 12 бүсэд гэхэд 808,161 га-гаар нэмэгдлээ. Ялангуяа төлөөлөл дутмаг экосистемийн уялдаа холбоо сайжирлаа.



Малчид цагаан идээ боловсруулж хүнсний хэрэгцээгээ хангахаас гадна нэмэлт орлого олж байна.

⁸ Хамгийн сайн боломжит арга зүй ба Байгаль орчны шилдэг практик дадал

⁹ Санамсаргүй байдлаар үүссэн органик бохирдуулагчууд

2.2.4. Гамшгийн эрсдэлийг бууруулах, даван туулах чадвартай иргэд олон нийт

Үндэсний статистикийн хорооны мэдээллээс үзэхэд, жил тутам гамшгийн улмаас бий болсон эдийн засгийн алдагдал 2020 оны эцэс гэхэд 108.2 тэрбум төгрөгт (ойролцоогоор 38.6 сая доллар) хүрсэн бөгөөд КОВИД-19-ийн нөхцөл байдал энэхүү эдийн засгийн алдагдлын төвшинд үлэмж хэмжээгээр нөлөөлжээ. Цар тахлын дэгдэлт болон үүний улмаас хөл хорио тогтоосон үед Монгол дахь НҮБ цар тахлын хариу арга хэмжээ авах, сэргээн босгох ажилд дэмжлэг үзүүлсээр ирлээ. НҮБ-аас Даян дэлхийн стратегийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдсан, хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх зарчимд суурилсан эдийн засаг, нийгмийн цогц хариу арга хэмжээ бүхий КОВИД-19-өөс сэргэх стратеги боловсруулахад нь Засгийн газарт дэмжлэг үзүүлэв.

Батлагдсан тохиолдол болон хавьтлын менежментийн системийг үндэсний болон орон нутгийн төвшинд бэхжүүлжээ. Монгол Улсын SARS-COV-2 лабораторийн туршилтын хүчин чадал НҮБ дэмжлэг үзүүлэхээс өмнөх үетэй харьцуулахад 10 дахин нэмэгдээд байна. КОВИД-19 цар тахлын хариу арга хэмжээний хүрээнд, КОВИД-19 болон бусад халдварт өвчинтэй тэмцэх зорилгоор Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг гурван улсын төв эмнэлэгт эрүүл мэнд, ариун цэвэр, эрүүл ахуйн орчныг сайжруулахад ашиглах фото каталик бүрэх технологийн дэмжлэг үзүүлэв.

НҮБ нь хувийн хэвшилтэй хамтран ус, ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжийг сайжруулахад хувь нэмэр оруулж, цэвэр агаарын төлөөх шинэлэг санхүүжилт, төр хувийн хэвшлийн түншлэлийн найдвартай суурийг тавихад чиглэсэн хөнгөлөлттэй ногоон зээлийг сурталчлан таниулахад дэмжлэг үзүүлсэн. Үүний сацуу, MICS Plus зэрэг нотлох баримт, өгөгдөл, санаачилгыг тодорхойлох зорилгоор бараг бодит цаг хугацааны үндэсний хэмжээний төлөөллийн өрхийн судалгааг хийгээд байна.

Улаанбаатар хотын захиргаа нь НҮБ-ын дэмжлэгтэйгээр КОВИД-19-ийн нөхцөлд шилжин суурьшлын нөхцөл байдлын үнэлгээ хийх аргачлалыг дэлхийн хэмжээнд анх удаа ашиглаж, нийслэл хот руу орсон болон хотоос гарсан 3,5 сая хөдөлгөөнд хяналт тавьж, Монгол Улсын дотоодод тархсан халдварын анхны тохиолдлыг илрүүлсэн бөгөөд нотолгоонд-суурилсан КОВИД-19-ийн хариу арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх талаар гүн гүнзгий ойлголттой болж авсан болно. КОВИД-19-ийн улмаас гадаадад гацсан 600 гаруй монгол иргэд НҮБ-ын үйл ажиллагааны дэмжлэгтэйгээр нутагтаа буцаж ирэв. КОВИД-19-ийн чиглэлээр үзүүлсэн дэмжлэгээс гадна зудын эрсдэлийн үнэлгээ, өвөлжилтийн хүнд байдлаас үүссэн цочрол, бэрхшээлийг бууруулах зорилгоор тусгайлсан санхүүжилт мөн хийгээд байна.

2.3 НҮБ-ЫН ХТХ-НИЙ ҮР ДҮНГИЙН ЧИГЛЭЛ ХОЁР : НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛАХ, ЧАНАРТАЙ, ТЭГШ, ХҮРТЭЭМЖТЭЙ НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ БИЙ БОЛГОХ




2020 оны 9-р сард Завхан аймагт НҮБ-ын хамтарсан хөтөлбөрөөс зохион байгуулсан үзэсгэлэнгийн үеэр малчдад нийгмийн даатгалын давуу талыг тайлбарлаж байна.

НҮБ-ын системийн 10 байгууллагын 33 хэрэгжүүлэгч түншүүдтэй хамтран хэрэгжүүлсэн 52 хөтөлбөрийн хүрээнд 32 сая долларын санхүүжилт хийлээ. Эдгээр зорилтот арга хэмжээ нь 10 аймаг, нийслэл Улаанбаатар хотыг хамарч хэрэгжсэн бөгөөд эдгээрийн зарим нь улсын хэмжээний нөлөөлөл үзүүлэв. Нийт санхүүжилтийг ядууралгүй, өлсгөлөнгүй, эрүүл мэнд болон сайн сайхан аж байдал, жэндэрийн тэгш байдал, ус,

ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламж, зохистой ажлын байр, тэгш бус байдал, тогтвортой хотууд, энх тайван, шударга ёс тогтоохтой холбоотой болон хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байхын тулд анхаарах асуудлыг өөртөө агуулсан КОВИД-19-ийн яаралтай хариу арга хэмжээ зэргийг багтаасан 10 ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд зориулж зарцуулаад байна.

Зураг 14: Үр дүнгийн чиглэл 2: 5П-ийн хүрээнд хүрээнд 10 ТХЗ-ыг хангахад чиглэсэн 32 сая ам. долларын зарцуулалт



2.3.1. Эрүүл мэнд

Эрүүл мэндийн салбарын нэгдсэн ололт амжилтын тухайд, эхний хагас жилийн байдлаар авч үзэхэд 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл өөрчлөлтгүй, тогтмол буюу тус тус 12 ба 15 байв. 2020 оны эхний хагаст эхийн эндэгдэл 2019 оны мөн үетэй харьцуулахад хоёр дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байсан хэдий ч, нийт нас баралт жилийн эцэс гэхэд 2019 онтой харьцуулбал жишихүйц төвшинд байсан байна (18 ба 23 тохиолдол тус тус). Жирэмсний хяналтад 6 ба түүнээс дээш удаа хамрагдсан эмэгтэйчүүдийн эзлэх хувь 81.6 хувьтай байгаа нь өмнөх жилүүдтэй харьцуулахад ялимгүй буурсан үзүүлэлт юм. Тэмбүүгийн тохиолдлын төвшин 2019 онд (10,000 хүн ам тутамд 56.2) 2018 онтой (10,000 хүн ам тутамд 50.8) харьцуулахад өсчээ. Энэхүү өсөлтийг Засгийн газраас хэрэгжүүлж буй “Тэмбүү өвчнийг устгах” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж буйн ачаар эрт оношилгоо сайжирч, бэлгийн замаар дамжих халдварын тандалтыг бэхжүүлсэнтэй холбон тайлбарлаж болно. Эрүүл мэндийн даатгалын хамрагдалт өндөр хэвээр буюу нийт хүн амын 91 хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдаж байна. 2019 оны байдлаар цусны даралт ихсэх өвчний илрүүлэг 71.7 хувь, 2-р хэлбэрийн чихрийн шижингийнх 71.9 хувьтай байгааг 2018 онтой харьцуулахад цусны даралт ихсэх өвчнийх 4.4 хувь, чихрийн шижингийн илрүүлэг шинжилгээ 4.1 хувиар тус тус өсчээ.

Дундаж наслалтын насны болон хүйсийн ялгаа 2015 оноос хойш тогтмол буурч ирсэн байна.

Ерөнхийдөө, Монгол Улсын эрүүл мэндийн салбар хамгийн бага хүчин чадалтайгаас тогтвортой үйлчилгээ үзүүлдэг өнөөгийн тогтолцоонд шилжих хүртэлх хөгжлийн замыг туулсан бөгөөд эдүгээ ТХЗ-ыг хангахад шаардлагатай гол чадавхыг бүрдүүлж чадсанаа харуулсан болно. Эрүүл мэнд, эрүүл мэндийн даатгал, эмнэлгийн тусламж үйлчилгээ, эмийн зохицуулалтын тухай цогц хуулиудыг баталж, томоохон бодлого, эрх зүйн шинэчлэлийг хийгээд байна. Эдгээр хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах нь 2020 онд КОВИД-19 цар тахлын үеэр бодлогын тэргүүлэх чиглэл байсан бөгөөд эдүгээ үүнийг ТХЗ-тай уялдуулах, эмзэг бүлэгт хүрч ажиллахад анхаарлаа хандуулах асуудлыг чухалчилж байна. Гэхдээ, 2020 онд тухайлбал, эх нялхсын эрүүл мэнд болон эрүүл мэндтэй холбоотой КОВИД-19 арга хэмжээний талаарх цаашид анхаарвал зохих тогтолцооны сул талыг олж тодорхойлоод байна. Гаргасан заавар, зөвлөмжийг дагаж мөрдөх, эмийн бус арга хэмжээ болон олон эх үүсвэрт тандалтыг бэхжүүлэх, төрөхийн өмнөх тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, улс орны өмнө тавигдсан зорилтыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах шаардлагатай байна.



Гэрэл зургийг ДЭМБ

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Эрүүл мэндийн төвийн ажилтан М. Энхмаа сумын төвөөс алслагдсан бөглүү тайгад амьдардаг цаатан иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж байна.

КОВИД-19 цар тахлын эсрэг болон тусламж, үйлчилгээг тасралтгүй үзүүлэх ажлыг дөхөм болгох зорилгоор НҮБ-аас техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлж, КОВИД-19-ийн менежмент, хавьтлыг тандан илрүүлэх, тусгаарлах, халдвараас урьдчилан сэргийлэх, хяналт тавих, эмнэлгийн хог хаягдлын менежмент, хүн амын шилжилт хөдөлгөөний менежмент, эх нялхсын эрүүл мэнд, амьсгалын замын хүндрэлийн менежмент зэрэг асуудлыг хамарсан түр хугацааны гарын авлагын талаар улсын хэмжээний цуврал сургалт зохион байгуулав.

Хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл (N95 ба мөс заслын зориулалттай амны хаалт, комбинзон, нөмрөг өмсгөл, гутлын уут буюу бүрхэвч, бээлий, нүүрний халхавч), эм, лабораторийн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмж (өвчтөний хяналт,

тариур, дусаах шахуурга, импульсийн оксиметр, насанд хүрэгсэд ба нярайн зориулалттай цусыг хүчилтөрөгчжүүлэгч), халдвараас урьдчилан сэргийлэх, хянах зориулалтын хэрэглэгдэхүүн (гар ариутгагч, халдваргүйжүүлэгч, шүршигч, автоклав), тусгаарлалтад байгаа эмэгтэйчүүд, охидод зориулсан иж бүрдэл, иргэдэд хүрч үйлчлэхэд ашиглах бэлэн мөнгөний (шатахууны зардал) дэмжлэг болон дэмжлэгийн шинжтэй хяналт зэргийг багтаасан нэмэлт тусламжийг улс, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад үзүүллээ. Цаашилбал, НҮБ-аас эх, нярайн эрүүл мэнд, жендэрт суурилсан хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн нөхцөл байдлын талаарх учир шалтгааны түргэвчилсэн судалгааг хийсэн бөгөөд үүнийг эрт илрүүлэлт ба хариу арга хэмжээтэй нэгтгэсэн болно.

2.3.2. Ус, ариун цэвэр, эрүүл ахуй

Ундны усны хүртээмжтэй холбоотой томоохон ахиц дэвшил гарсан бол харин ариун цэврийн байгууламжийн сайжруулсан үйлчилгээний тухайд багахан ахиц дэвшил гарчээ. 2016-2018 оны хооронд ундны усны эх үүсвэртэй хүн амын эзлэх хувь 64-өөс 94 хувь хүртэл өссөн бол сайжруулсан ариун цэврийн байгууламжтай хүн амын эзлэх хувь 59-аас 62 хувьд хүрч өссөн дүнтэй байна. НҮБ-ын системийн байгууллагуудын техникийн туслалцаатайгаар, усны аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлж, хотын ус



Гэрэл зургийг НҮБ-Хабитат

Улаанбаатар хотын гэр хорооллын иргэдийн хувьд дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний хүртээмж харилцан адилгүй байна.

ханган нийлүүлэгчид болон орон нутгийн чанартай усны эх үүсвэрийг зорилтоо болгох замаар улсын хэмжээний болон орон нутгийн төвшний Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэв.

Эмзэг бүлгийн иргэд, сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төвүүдэд үерийн хамгаалалт, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус, ариун цэвэр,

2.3.3. Чанартай боловсролыг дэмжих

Цар тахлын үзүүлсэн нөлөөг боловсролын статистик мэдээллээс харж болно. Суурь боловсролд хамрагдалтын төвшин 2016 онд 91.4 байсан бол 2019 онд 97-д хүрсэн боловч хамгийн ядуу бүлгийн хүүхдүүдийн дөнгөж 71 хувь нь дунд боловсролд хамрагдсан байна. Бага насны хүүхдийн боловсролд хамрагдалтын улсын дундаж 74 хувь байхад, хамгийн ядуу бүлгийн хүүхдүүдийн зөвхөн 34 хувь нь хамрагджээ. Бага насны хүүхдийн хөгжлийн индекс нь орлогын төвшнөөс хамаарсан ялгаа төдийлөн байхгүйг харуулж буй бөгөөд орлогын төвшнөөрөө хамгийн доод 20 хувьд хамаарах өрхийн хүүхдүүдийн 86 хувь нь бие бялдрын болон оюун ухааны хөгжлөөрөө хүрсэн байвал зохих төвшинд байна. 4, 8-р ангийн хүүхдүүдийн дөнгөж 56 ба 57 хувь нь тус тус тоон ойлголтын үндсэн чадварыг эзэмшсэн байгаа нь боловсролын чанартай холбоотой сорилт тулгарсаар байгааг харуулж байна. Гэхдээ, онцлон тэмдэглэвэл зохих нэгэн зүйл гэвэл, 2017 оноос хойш хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургуульд хамрагдалт хоёр дахин нэмэгдэж, 72 хувьтай болоод байгаа явдал юм.

НҮБ-аас Монгол Улсад үзүүлж буй техникийн туслалцаа дэмжлэг, бодлогын зөвлөгөө нь хүртээмжтэй байдал, өндөр чанартай боловсрол, насан туршийн боловсролоор тодорхойлогддог мэдлэгийн эдийн засгийн боловсролын тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлэх замаар институцийн чадавхыг дээшлүүлэхэд чиглэгдсэн бөгөөд энэ нь Засгийн газраас өнөөгийн боловсролын тогтолцоог даян дэлхийн тогтвортой хөгжлийн хөтөлбөртэй уялдуулан үндсээр нь шинэчлэх хүсэл тэмүүллийн суурь нь болж өгч байна. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас (БСШУЯ) ТХЗ 4-тэй уялдсан, түүний салшгүй хэсэг нь болох 2050 он хүртэлх Монгол Улсын боловсролын салбарын урт хугацааны алсын хараа болон Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөг

эрүүл ахуйн байгууламжийн үзүүлэн таниулах төслүүдийг хэрэгжүүлснээр 250 гаруй мянган хүн үр шимийг нь хүртээд байна. Чадавхыг бэхжүүлэх, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх замаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний байгууллагуудын ус, ариун цэвэр, эрүүл ахуйтай холбоотой өвчин, КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлэв.



НҮБ-ын Хүүхдийн сан болон Скаутуудын холбоо хамтран өсвөр насныханд зориулсан эрүүл ахуйн сургалт

(БСХДХТ) дэд салбаруудын бодлогын судалгааны тайлангийн нэгтгэлд үндэслэн боловсруулаад байна. Чадавхыг бэхжүүлэх, бодлогын судалгаа хийх, боловсролын салбарын гол стратеги болон Монгол Улсын нийгэм, эдийн засгийн урт хугацааны хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад бүх оролцогч талууд болон хөгжлийн түншүүдийг татан оролцууллаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх институцийн чадавх дутагдалтай байгаа тул, БСШУЯ ТХЗ 4 болон боловсролын салбарыг

2021-2030 онд хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт тавих Хяналт шинжилгээ, үнэлгээний алба байгуулахаар тохиролцов. НҮБ нь КОВИД-19-ийн үеэр хүүхэд, гэр бүлийг дэмжихийн тулд, хүүхэд хамгааллын үйлчилгээний байгууллагуудтай хамтран нэгдсэн зохион байгуулалттай арга хэмжээ авах замаар хүүхдүүд тасралтгүй суралцах боломжоор хангагдахад чухал үүрэг гүйцэтгэсэн.

2.3.4. Хүнсний чанарыг сайжруулах

НҮБ-аас Монгол Улсын хүнсний аюулгүй байдлын талаарх хууль эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор олон хууль тогтоомж, стандартын талаар техникийн мэдлэг туршлага санал болгосон бөгөөд үүнд 1) Баяжуулсан хүнсний тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор Засгийн газарт оруулсан баяжуулагч бэлдмэл, баяжуулсан гурил, иоджуулсан давсны лабораторийн шинжилгээний стандарт; 2) хууль, төрийн бодлогод нарийвчилсан үнэлгээ хийх үндсэн дээр өгсөн Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах талаарх зөвлөмж; 3) хөдөө аж ахуйн хялбаршуулсан шилдэг практик дадал (GAP) ба хортон шавьжтай тэмцэх менежментийн (IPM) зааварчилга боловсруулах, орон нутгийн жимс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор таримал ургамлын үр, сортын тухай хуулийг шинэчлэх асуудал; 4) Хөдөө аж ахуйн салбарт технологийн дэвшлийг нэвтрүүлэх зорилгоор Засгийн газраас баталсан Монгол Улсын Цахим хөдөө аж ахуйн стратеги, эдүгээ хийгдэж буй сонгосон шийдлүүдийн туршилт; 5) Засгийн газарт батлуулахаар оруулсан Мал, амьтны шүлхий өвчинтэй тэмцэх 4 жилийн үйл ажиллагааны стратеги болон дэгдэлтийг судлан тандах үйл ажиллагааны стандарт журам багтсан болно.

Эрүүл хүнс, зөв хоолны дэглэмийн орчин бүрдүүлэхэд үзүүлсэн дэмжлэг Монгол Улсын хүнсний аюулгүй байдал, илчлэг буюу шим тэжээлийн тооцооллыг сайжруулав. 2014, 2016, 2018 оны өрхийн нийгэм-эдийн засгийн судалгааны (ӨНЭЗС) дүн шинжилгээнд үндэслэн



Бага насныханд эрүүл хооллолтын талаарх сургалт

ADePT модулийг ашиглан тооцоолсон хүнсний аюулгүй байдлын статистик мэдээллээс харахад, Монгол Улсын хүнсний аюулгүй байдал (хангамж, хүртээмж, хэрэглээ, тогтвортой байдал) хангалттай бөгөөд тогтвортой байх нөхцөлийг хараахан хангаагүй гэж дүгнэж болохоор байна. Хүнс, хүнсний шим тэжээлийн зохистой байдлыг сайжруулахын тулд энэ талаар олон нийтэд сурталчлан таниулах үйл ажиллагаа чухал ач холбогдолтой бөгөөд НҮБ-ын системийн байгууллагууд энэ чиглэлээр улс, бүс нутаг, аймгийн төвшинд үргэлжлүүлэн дэмжиж ажиллах болно.

Хүнсний аюулгүй байдал, хүнсний шим тэжээлийн чиглэлийн мэдэгдэхүйц үйл ажиллагааны тоонд 66 сургуулийн сурагчдын өдрийн хоолны багц жорыг стандартчилах, 210 сургуулийн тогооч нарт сургалт явуулах, нялхас болон бага насны



Малчны хот

хүүхдийн хоол тэжээл болон хог хаягдлын менежментийн чиглэлээр 4134 эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулах, 360 төрийн албан хаагч, тариаланч, агрономич, байцаагч нарыг GAP, IPM болон GAP аудиторуудын сургалтад хамруулах, шүлхий өвчний тархалтыг хянах, хариу арга хэмжээ авах чиглэлээр 359 мал эмнэлгийн тархвар судлаачдыг сургах, шүлхий өвчний тархалтыг хянахад дэмжлэг үзүүлэх зорилгоор эмзэг бүлгийн малчдыг 250,000 тун шүлхий өвчний вакцинаар хангах зэрэг үйл ажиллагаа багтсан болно.

Цар тахлын үеэр 9 төрлийн хүнсний ногооны нийт 3400 кг үрээр тариаланчдыг хангах тусламж үзүүлснээр орон нутгийн хүнсний ногооны хангамж нэмэгдсэн. Эдүгээ Засгийн газар хүнсний ногооны хэрэгцээний 44.6 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой болоод байна. 5-аас доош насны 309,166 хүүхдэд А аминдэмийн бэлдмэл өгч, хоол тэжээлийн дутагдалд орсон 439 хүүхдэд сэхээн амьдруулах яаралтай тусламж үзүүллээ. Түүнчлэн, 221 эрүүл мэндийн байгууллага хоол тэжээлийн зайлшгүй шаардлагатай нөөц хүлээн аваад байна.

2.3.5. Нийгмийн хамгаалал


НҮБ-аас Завхан аймгийн 5 сумын малчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг 10 хувь, улсын хэмжээнд 5 хувиар нэмэгдүүлэхэд шууд болон дам байдлаар хувь нэмэр орууллаа¹⁰. НҮБ нийгмийн даатгалын хөтөлбөрийн үр өгөөжийг сурталчлах зорилгоор зиндаа нэгтнээсээ суралцах аргыг нэвтрүүлж, малчид болон уламжлалт бус түншүүдийг нийгмийн даатгалыг сурталчлан таниулагчийн сургалтад хамруулсан. Энэ нь уламжлалт бус, харин практик дадал суулгах арга юм. НҮБ-аас Хүүхдийн мөнгөний хөтөлбөрийг (ХМХ) босоо байдлаар өргөжүүлэх замаар бүх төрлийн цочролд өртөх эрсдэлтэй хөдөө орон нутгийн хүүхдүүдэд зориулсан Шоконд хариу үйлдэл үзүүлдэг нийгмийн хамгааллын хөтөлбөрийг (НХҮДХ) туршин хэрэгжүүлээд байна.

НҮБ-аас хүүхдийн мөнгөний хөтөлбөр болон хүнсний талоны хөтөлбөрийг (ХТХ) хэрэгжүүлэх чиглэлээр авсан цар тахлын хариу арга хэмжээнд хяналт тавих, улмаар цаашдын шийдвэр гаргахад хэрэгтэй нотолгоо, сургамжаар хангагдахад Засгийн газрыг дэмжиж ажиллав. Эдгээр үйл ажиллагаа нь нийгмийн хамгааллын үндэсний тогтолцоонд Шоконд хариу үйлдэл үзүүлдэг нийгмийн хамгааллын хөтөлбөрийг нэвтрүүлэхийн ач холбогдлыг таниулж өгсөн. НҮБ-аас малчин өрхийн уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэл, цочролыг даван туулах чадварт дүн шинжилгээ хийх зорилгоор Даван туулах чадварын индексийн хэмжилт, шинжилгээ (RIMA-II)-г Монголд нэвтрүүлж эхэллээ. НҮБ-аас залуу малчдын амьжиргааг дэмжиж, бизнес эрхлэх ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлээд байна.

НҮБ нь олон нийт болон халуун цэгт ажиллагсдын КОВИД-19, үүнтэй холбоотой хязгаарлалтын нөлөөллийг даван туулах чадварыг бий болгоход чиглэсэн үйл ажиллагаанд хувь нэмэр оруулав. Бусдын нэр төрийг гутаах гүтгэлгийн эсрэг аян, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаарх зурвасууд 1.5 сая хүнд хүрч, эмзэг бүлгийн 2500 өрх яаралтай тусламжийн багц хүлээн аваад байна. НҮБ нь онцгой байдлын үед нийгмийн эмзэг бүлэгт сэтгэл зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлдэг нийгмийн ажилтнууд зэрэг халуун цэгт

ажиллагсдын чадавхыг дээшлүүлсэн бөгөөд хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл, тусгай тоног төхөөрөмжийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Онцгой байдлын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хүлээлгэж өглөө. НҮБ-аас хөл хорионы улмаас дотооддоо гацсан 68000 иргэнийг орон нутагт нь аюулгүй буцаах үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлээд байна. КОВИД-19-ийн хариу арга хэмжээ авах хүчин чармайлтад одоо байгаа болон дараа дараагийн дотооддоо шилжин суурьшигчдыг мэдээллээр хангах, сэтгэл зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх зорилгоор 10 аймаг, Улаанбаатар хотод орон нутгийн ТББ-уудын сүлжээ байгуулахыг дэмжиж ажиллалаа.

Зураг 15: КОВИД-19 цар тахлын үеэр Засгийн газраас тэтгэмж авсан өрхийн эзлэх хувь, хот хөдөөгөөр



Эх сурвалж: YCX, НҮБ-ын Хүүхдийн сан. MICS Plus 2020-2021

Засгийн газар КОВИД-19 цар тахлын үеэр иргэдийн амьжиргааг хамгаалах чиглэлээр төрөл бүрийн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. “Хүүхдийн мөнгө” хөтөлбөрт нийт өрхийн 68 хувь нь буюу хүүхэдтэй өрхүүдийн ийн 98 хувь нь хамрагдсан байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрөөс чөлөөлөлт хот суурин газарт илүү давамгайлсан (хөдөө орон нутагт 19 хувь, хотод 31 хувь) бол хөдөө, орон нутгийн өрхүүдийн 61 хувь, харин суурин газрын өрхийн 5 хувь нь ноолуурын урамшуулал авчээ.

¹⁰ Нийгмийн даатгалын ерөнхий газар

2.4 НҮБ-ЫН ХТХ-НИЙ ҮР ДҮНГИЙН ЧИГЛЭЛ ГУРАВ:

ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИЖ, ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ



International
Labour
Organization



World Health
Organization
Representative Office
for Mongolia



UN HABITAT
FOR A BETTER URBAN FUTURE

unicef
for every child



ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ:

2021 он гэхэд засаглалын байгууллагууд нь залуучуудын идэвхтэй оролцоог дэмжиж, ядуу, эмзэг, бүлгийнхний болон хүн бүрийн хүний эрхийг дээдэлж, ард иргэдийнхээ өмнө илүү нээлттэй байж, хүлээх хариуцлагаа дээшлүүлсэн байна.




Орон нутгийн иргэд тулгамдсан асуудлаа тодорхойлж, гарц шийдлийг хамтдаа эрэлхийлж байна.

Энэхүү үр дүнгийн хүрээнд үзүүлсэн дэмжлэг нь улс орны хөгжил хүртээмжтэй, тогтвортой байх, бүгдийн эрхийг, түүний дотор залуучууд, эмзэг бүлгийнхний эрх ашгийг хамгаалах, тэдний хэрэгцээнд нийцсэн байх явдлыг баталгаажуулахын тулд хууль эрх зүйн орчин зэрэг засаглалын институцийн чадавхыг сайжруулахад чиглэгдэв. НҮБ-ын системийн 8 байгууллага хамтран 25.0 сая ам.доллар

татан төвлөрүүлсэн бөгөөд энэхүү үр дүнгийн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд 26 түнш байгууллагатай хамтран ажиллаж эрүүл мэнд, сайн сайхан аж байдал, жендэрийн эрх тэгш байдал, зохистой хөдөлмөр, тогтвортой хотууд, энх тайвныг эрхэмлэхтэй холбоотой 5 ТХЗ-ыг хангахад 19.0 сая ам. долларыг зориулж зарцуулаад байна.

Зураг 16: Үр дүнгийн чиглэл 3: 5П-ийн хүрээнд 6 ТХЗ-ыг хангахад чиглэсэн 18.9 сая ам. долларын зарцуулалт



2.4.1. Хууль эрх зүйн хамгааллын механизм

2020 оны байдлаар Эмэгтэйчүүдийг алагчлах бүхий л хэлбэрийг устгах тухай конвенцын (ЭАБХУК) зөвлөмжийн 90%, Хүний эрхийн хэрэгжилтийг хянах нийтлэг механизм (UPR)-ын зөвлөмжийн 86.1%-ийг Монгол Улсын Засгийн газар хүлээн авч, одоогоор Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд голчлон хэрэгжүүлж байна.

НҮБ мөн, Монгол Улсын Засгийн газарт хүний эрхийг дээдлэн хамгаалах, түүний дотор хүчирхийллээс ангид байх эрхийг хамгаалах хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эдгээр хуулийг хэрэгжүүлэх, хуулийн хэрэгжилтэд хяналт тавихад дэмжлэг үзүүлж ирсэн.

Тодорхой дурдвал, жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ), хүүхдийн эсрэг хүчирхийлэл (ХЭХ), мөн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, хүчирхийлэл үйлдэгчдэд хариуцлага тооцох механизмыг хуулиар тогтоосон бөгөөд эдгээр механизмыг олон улсын стандарт буюу жишиг болон шилдэг практик дадалд нийцүүлэн тасралтгүй сайжруулж байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль зэрэг томоохон хуулиас гадна НҮБ-аас салбаруудын хэмжээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг удирдан чиглүүлэх үйл ажиллагааны нийтлэг журам, удирдамж, кодыг боловсруулахад техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүллээ. Эдгээр хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, НҮБ болон иргэний нийгмийн байгууллагуудын шугамаар сурталчлан таниулах ажлыг өргөн хүрээнд зохион байгуулснаар жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад чиглэсэн Засгийн газрын үйл ажиллагаа сайжирсан нь 2017-2020 онуудад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй холбоотой арга хэмжээнд зориулж зарцуулсан улс, орон нутгийн төсвийн хөрөнгө 6.2 тэрбум төгрөг болж нэмэгдсэнээр нотлогдож байна. Үүнийг НҮБ-аас чадавхыг бэхжүүлэх, мэдрэмжтэй хандах чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээгээр дамжуулан дэмжиж, энэ хүрээнд,

Зураг 17: Хууль эрх зүйн шинэчлэлд үзүүлсэн дэмжлэг

Хууль эрх зүйн шинэчлэлийг дэмжив	
Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль	
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль	
Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль	
Хүүхэд хамгааллын тухай хууль	
Эрүүгийн хууль (Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэсэг)	
Зөрчлийн тухай хууль (Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэсэг)	
Хөдөлмөрийн тухай хууль	
Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль	
Хууль шинэчлэх техник, санхүүгийн дэмжлэг	Хэрэгжүүлэхтэй холбоотой техник, санхүүгийн дэмжлэг
Ухуулга, сурталчилгаа	Хяналт, үнэлгээ

Жендэрийн үндэсний хороо (ЖҮХ), Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Сургалт, судалгааны төв тус тус байгуулагдсан бөгөөд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг олж илрүүлэх, тэдэнд үйлчилгээ үзүүлэх талаар үүрэг хүлээгчдэд иж бүрэн сургалт явууллаа. Эдгээр хүчин чармайлтын үр дүнд, зөвхөн 2020 онд гэхэд, жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн 3799 хохирогч нэг цэгийн үйлчилгээнд хамрагдсан, эсхүл хамгаалах байрнаас тусламж дэмжлэг авсны 2992 нь НҮБ-ын дэмжлэгтэй Нэг цэгийн үйлчилгээгээр дамжуулж болон хамгаалах байрнаас туслалцаа авсан ба 9192 хүүхэд хамгаалах тохиолдлыг олон салбарын төлөөллийн баг, нийгмийн ажилтнууд хянан шийдвэрлэсэн байна. КОВИД-19 цар тахлын үеэр НҮБ-ын техникийн болон санхүүгийн дэмжлэгтэйгээр, эдгээр төвүүдийн ажилтнуудыг хөл хорионы үед ажиллах нэн шаардлагатай ажиллагсдын ангилалд багтаасан бөгөөд НҮБ-ын зүгээс хийсэн идэвхтэй сурталчлан таниулах үйл ажиллагааны үр дүнд эдгээр үйлчилгээг аюулгүй байдалд тасралтгүй үзүүлж ирсэн байна. Нэмж дурдахад, НҮБ-аас хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч 7 монгол эмэгтэйг эх оронд нь авчрах, ирснийх нь дараа нийгэмшихэд нь дэмжлэг үзүүлэхийн сацуу хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон гадаадын 3 эмэгтэйг эх орондоо буцахад нь туслалцаа үзүүлээд байна. Гэхдээ, Жендэрт суурилсан хүчирхийллийн хоёр дахь удаагийн улсын хэмжээний судалгааг НҮБ-ын ХТХ-ний тайлант хугацаанд хийхгүй тул жендэрт

суурилсан бүхий л хэлбэрийн хүчирхийллийн тохиолдлуудад эдгээр санаачилгын үзүүлсэн нөлөөллийг хараахан хэмжих боломжгүй байв.

НҮБ нь Хөдөлмөрийн тухай хуулийг шинэчлэн боловсруулах, Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, үйлдвэрлэлийн орчны тухай ОУХБ-ын конвенцыг соёрхон батлах замаар ажилчдын эрхийг хамгаалах, Засгийн газар, ажил олгогч, ажилчид хоорондын яриа хэлцлийг бэхжүүлэх замаар албан бус ажилчдыг албан ёсны хэлбэрт шилжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг хүний эрхийг хамгаалахтай холбоотой нэн чухал шинэчлэл хийхэд дэмжлэг үзүүлээ. Үүний зэрэгцээ, НҮБ нь тухайлбал, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, мөн төрийн албан дахь томилгооны үр ашиг, чанарыг сайжруулахад чиглэсэн төрийн албаны шинэтгэлээр дамжуулан Монгол Улсын Засгийн газрын төвшинд сайн засаглал, ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэхэд техникийн болон санхүүгийн туслалцаа үзүүлээд байна. Эдгээр хууль тогтоомжийн шинэчлэлийг хэрэгжүүлэх зорилгоор хараат бус үнэлгээ хийх замаар эдгээр гол хуулиудын хэрэгжилтэд хяналт тавих, үнэлгээ хийх, тогтмол хяналт тавих механизм, горим журам бий болгоход нь Монгол Улсын Засгийн газарт мөн дэмжлэг үзүүлсэн. Эдгээр хүчин чармайлтын үр дүнг Монгол улсад хүний эрхийг хамгаалж, дээдлэхэд чиглэсэн эдгээр хуулийн үр ашиг болон үр нөлөөг дээшлүүлэхэд ашигласан болно.

2.4.2 Эмэгтэйчүүд, залуучуудын төлөөлөл

2020 оны сонгуулийн дараа орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд (ИТХ) эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин 28 хувь хэвээр үлдсэн нь бүс нутгийн дундаж болох 33 хувиас доогуур байна. ИТХ-ууд НҮБ-ын дэмжлэгтэйгээр туршин хэрэгжүүлсэн эмэгтэйчүүд, залуучууд, нийгмийн эмзэг бүлгийнхэнд итгэл төрүүлэх механизмыг шийдвэр гаргах үйл явцад эмэгтэйчүүд, залуучуудын оролцоо, төлөөллийг нэмэгдүүлэх зорилгоор ашиглаж байна. Энэ хүрээнд хийсэн ажлын үр дүнд, хурлаар хэлэлцэх асуудлын талаар санал дэвшүүлэх аливаа иргэний (түүний дотор төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж) эрхийг институтчилсэн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны шинэчилсэн жишиг журамтай болж, мөн хуралдааны бүх тэмдэглэл болон холбогдох баримт бичгийг олон нийтэд нээлттэй болгох шаардлага тавигддаг болсон.



Сумын ИТХ-ын тэргүүлэгчид орон нутгийн хөгжлийн асуудлыг хэлэлцэж байгаа нь.

НҮБ, Монгол Улсын Засгийн газар хамтран залуучуудын оролцооны платформ үүсгэхэд тус дэм үзүүлсэн бөгөөд улмаар 21 аймаг, 301 сум, Улаанбаатар хотын 8 дүүрэгт 331 залуучуудын орон нутгийн зөвлөл байгуулагдаад байна. Эдгээр зөвлөлүүд нь залуучуудыг цугларч уулзах орон байраар ханган улс орны өмнө тулгараад

буй хүндрэл бэрхшээлийн талаар хэлэлцэх боломжоор хангадаг болсон ба үүний үр дүнд залуучуудыг хөгжүүлэх чиглэлээр авсан үүрэг амлалтаа Засгийн газар нэмэгдүүлсэн бөгөөд улсын хэмжээнд залуучуудын хөгжилд зориулж нийт 420 сая төгрөгийг аймгуудын төсвөөс хуваарилсан болно.

2.4.3. Залуучуудын сүлжээ ба байгууллагууд



НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгээр байгуулагдсан Залуучуудын хөгжлийн төв

Залуучуудын сүлжээ улсын хэмжээнд байгуулагдсан 35 Залуучуудын Хөгжлийн Төвд (ЗХТ) үүсч бий болоод байна. Эдгээр ЗХТ нь залуучуудад нийгмийн амьдралд бэлтгэгдэх, бусадтай харилцах найдвартай орчныг бүрдүүлэхээс гадна залуучуудад ажил, амьдралын үр чадвар эзэмшүүлэх, олон талын асуудлаар зөвлөх үйлчилгээ авах, өөрсдөд нь хамаатай асуудлаар шийдвэр гаргах үйл явцад оролцох боломжийг олгодог. НҮБ эдгээр 35 ЗХТ-ийн 19-ийг нь байгуулахад дэмжлэг үзүүлсэн бөгөөд тэдгээрийн үйл ажиллагааг үргэлжлүүлэхэд орон нутгийн засаг захиргаанаас дэмжлэг үзүүлж ажиллахыг уриалсан. Үүний үр дүнд ЗХТ-үүд 2020 онд гэхэд нийт 84601 өсвөр насныхан, залуучуудад үйлчилгээ үзүүлээд байна. ЗХТ-дэд төвлөрсөн залуучуудын боломж, чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаа олон нийтийн төвшинд хэл болон агуулгын хувьд нутагшиж, энэ хүрээнд олон улсын “Хүүхэд, залуучууд, гэр бүлд боломж олгож, чадавхжуулах: эрх, үүрэг хариуцлага, төлөөлөл” гэсэн 3-R-ын талаар сургагч багш нарт зориулсан гарын авлагыг түгээгээд байна. Энэхүү гарын авлага нь тухайн чиглэлээр албан

үүрэг гүйцэтгэгчдэд гэр бүл, орон нутгийн оршин суугчдын хүүхэд, залуучуудын чадавхыг бэхжүүлэхэд төдийгүй хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, хүүхэд худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүүхэд, залуучуудыг худалдаалах эрсдэлийг хэрхэн бууруулах талаар суралцах боломж олгодог. НҮБ-аас залуу эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэх эрхийг хөхүүлэн дэмжих зорилгоор зохистой ажлын байрны төлөөх төрийн болон төрийн бус байгууллагуудын залуучуудын сүлжээг байгуулахад дэмжлэг үзүүлсэн. НҮБ-аас “Идэвхэжсэн 2030” санаачилга, Залуучуудын самбаачлал санаачилгаар дамжуулан ТХЗ-уудыг хангахад чиглэсэн бизнес эрхлэх чадавхаа хөгжүүлэх аяныг УБ хот, Завхан, Орхон аймагт зохион байгууллаа.

Эцэст нь тэмдэглэхэд, Монголын залуучууд НҮБ-аас, тухайлбал, КОВИД-19 цар тахлын үеэр зохион байгуулсан бүтээн байгуулалт, хүмүүнлэгийн арга хэмжээнд өргөн хүрээнд идэвхтэй оролцсон болно. НҮБ нь 117 сайн дурын ажилтан залуучуудтай (үүнээс 60 нь охид) хамтран КОВИД-19-өөс урьдчилан сэргийлэх талаар мэдлэг олгох, цар тахалтай холбоотой түргэвчилсэн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулав. Сайн дурын ажилтан залуучуудын хийсэн судалгааны үр дүнг НҮБ болон Эрүүл мэндийн яамны хамтран боловсруулсан урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон протокол боловсруулахад анхааралдаа авсан болно. Үүний сацуу, НҮБ-аас Монголын Скаутын холбоо зэрэг залуучуудын бүлгүүдийг цэвэр агаар санаачилга, сургуулиудын ус, ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламж, сарын тэмдгийн эрүүл ахуй, ариун цэвэр зэрэг залуучуудын оролцоог өргөжүүлэх зорилго бүхий үйл ажиллагаанд оролцууллаа. Эдгээр үйл ажиллагаанд нийт 774 сайн дурын ажилтан залуучууд (үүнээс 538 нь охид байсан) хамрагдсан бөгөөд тэд шууд болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийт 22,925 хүнд хүрч үйлчлээд байна.

2.5. 2030 ОН ХҮРТЭЛХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН ТҮНШЛЭЛ БА САНХҮҮЖИЛТИЙН ДЭМЖЛЭГ

Хөгжлийн түншүүд Засгийн газрын манлайллын дор хэрэгжүүлж ирсэн КОВИД-19-ийн нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээнд зориулж нийт 313 сая долларын санхүүжилт татан төвлөрүүлэв. Засгийн газар нь хөгжлийн түншүүд, үүний дотор НҮБ-ын дэмжлэг болон эдийн засгийг дэмжих арга хэмжээнд зориулсан санхүүжилтийн тусламжтайгаар 3.2 сая хүн амдаа нийгмийн хамгаалал болон суурь үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ ажлын байр, амьжиргааг хамгаалахын тулд жижиг, дунд үйлдвэр, албан бус салбарын ажилчдыг дэмжих замаар цар тахлын нөлөөллийг хамгийн бага төвшинд байлгах боломж бүрдүүлээд байна. Түүнчлэн, НҮБ-аас Монгол Улсын Засгийн газартай хамтран цочролын хариу арга хэмжээг нэмэгдүүлэх замаар малчдыг нийгмийн хамгааллын тогтолцоонд хамруулах нөхцөлийг бүрдүүлсэн болно. Энэхүү хамтарсан хөтөлбөрийн хүрээнд уур амьсгалын өндөр эрсдэлтэй бүс нутагт хүүхдийн мөнгөний хөтөлбөрийг туршин хэрэгжүүлсэн бөгөөд үр дүнд нь хүүхэдтэй гэр бүлд туслах зорилгоор 300 орчим сая ам.доллар хуваарилж, цар тахлын эдийн засгийн сөрөг үр дагаврыг арилгахад зориулж зарцуулсан ба ингэснээр хоол хүнс болон бусад зайлшгүй хэрэглээнд зарцуулах зардлыг бууруулах зэрэг сөрөг үр дагавартай стратегиудыг ашиглахаас зайлсхийж чадсан юм.

ТХЗ-ийн санхүүжилтийг бүрдүүлэхийн төлөө хамтдаа

Тогтвортой хөгжлийг дэмжихийн тулд дотооддоо болон олон улсын төвшинд нөөц татан төвлөрүүлэх асуудал Монгол зэрэг хөгжиж буй олон улс орны хувьд гол тулгамдсан асуудал хэвээр байна.

Монгол дахь НҮБ нь Дэлхийн банк, АХБ, Олон улсын валютын сан, ЕХ-той хамтран ТХЗ-уудыг ханган биелүүлэхэд чиглэсэн төрийн санхүүгийн менежментийн чадавхыг сайжруулахад нь Засгийн газарт дэмжлэг үзүүлсээр ирсэн. 2020 онд, Сангийн яам, НҮБХХ-ийн хооронд ТХЗ-тай уялдсан, үр дүнд чиглэсэн төсөвлөлт, нэгдсэн санхүүжилтийн хүрээ, төсвийн ил тод байдал, тайлагналын чиглэлээрх түншлэлийг баталгаажуулсан Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зураад байна. ТХЗ-г хангахад чиглэсэн төсвийн санал боловсруулах туршилтыг өргөжүүлж, 2020 онд гэхэд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам

болон Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хэрэгжүүлээ.

Монгол дахь НҮБ нь, НҮБ-ын ТХЗ-ын хамтарсан сангийн санхүүжилтээр Монгол Улсын Үндэсний санхүүгийн нэгдсэн хүрээг (ҮСНХ) боловсруулах үйл явцыг дэмжиж ажиллав. ҮСНХ нь төрийн болон хувийн хэвшлийн санхүүжилтийн бүх эх үүсвэрт тулгуурлах үндсэн дээр үндэсний хөгжлийн стратегийг хэрхэн санхүүжүүлж, хэрэгжүүлэх боломжтойг үндэслэлтэйгээр гаргаж харуулдаг. ҮСНХ нь төлөвлөлтийн үйл явцыг бэхжүүлэх, тогтвортой хөгжил болон ТХЗ-уудыг үндэсний төвшинд санхүүжүүлэхэд тулгарч буй бэрхшээлийг даван туулахад нь улс орнуудад туслах төлөвлөлт, гүйцэтгэлийн арга хэрэгсэл юм. Техникийн ажлын хэсгийг Сангийн яамны дэргэд байгуулсан бөгөөд уг ажлын хэсэг анхны үнэлгээ, дүн шинжилгээний ажлыг ид хийж байна.

ТХЗ-ын төлөөх төр, хувийн хэвшлийн түншлэлийг амжилтанд хүргэхээр хамтран ажиллав

ТХЗ-уудыг хангах нь бүх оролцогч талуудын хувьд чухал ач холбогдолтой бөгөөд хувийн хэвшлийнхэн ТХЗ-ыг санхүүжүүлэх болон ханган биелүүлэхэд чухал үүрэгтэй. Монгол дахь НҮБ нь улс орны тогтвортой хөгжилд уг салбарын чадавхыг ашиглах зорилгоор төр, хувийн хэвшлийн түншлэлийг үлгэрлэн ажиллаж байна.

Оюу Толгой (ОТ) болон НҮБ хоорондын шинэлэг түншлэл нь Ханбогд сумын залуучуудад өөрсдийн чадавхыг бүрэн ухамсарлахад нь тусалж, Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндэд дэмжлэг үзүүлэв. ОТ компанийн НҮБ-ийн үйл ажиллагаанд оруулсан санхүүгийн нэмэр хандив нь залуучуудад амьдрах ухаанд суралцаж, хариуцлагатай, эерэг, бие даах чадвартай хүн болж төлөвшихөд нь туслахад зориулагдсан бөгөөд ингэснээр залуучууд өөрсдөө амьдралынхаа чанарыг дээшлүүлж, улс болон орон нутгийнхаа хөгжилд эерэгээр хувь нэмрээ оруулах боломж бүрдүүлж буй юм. Төр, хувийн хэвшлийн эдгээр түншлэлээр дамжуулан залуучуудыг чадавхжуулах, тэдэнд өөрсдөд нь хамаатай асуудлаар бодлого, шийдвэр гаргахад нөлөөлдөг чадавхтай болгох зорилгоор аймаг, сумын төвшний залуучуудын оролцооны платформ бий болгож бэхжүүлээд байна.

ХАЗЕ ГАЗЕР

НҮБХХ, НҮБ-ын Хүүхдийн сангийн хамтран хэрэгжүүлж буй "Агаарын бохирдолд тавих олон нийтийн хяналт" хамтарсан санаачилгын хүрээнд "Инновацийн сорилтын дуудлага" арга хэмжээнд оролцсон 196 оролцогчид дундаас шилдэг таван төслийг шалгаруулсан. Агаарын бохирдол нь хүүхэд, эхчүүдийн эрүүл мэндэд ноцтой эрсдэл учруулж байгаа бөгөөд Засгийн газар, хөгжлийн түнш байгууллагууд, ТББ-уудын анхаарлын төвд байсаар ирсэн асуудал. Гэхдээ, өгөгдөл, нотолгоо байгаа хэдий ч, нарийвчилсан дүн шинжилгээ хийхэд хангалтгүй бөгөөд чанарын баталгаажуулалт шаардлагатай байгаа юм. Уг асуудлыг шийдэхийн тулд уламжлалт бус эх сурвалж, том өгөгдлийг агаарын бохирдолтой холбоотой арга хэмжээ авах, хөтөлбөрийн үр дүнд үнэлгээ хийхэд ашиглах явдал өөр нэгэн хувилбар байж болно гэж үзсэн. НҮБ-ын Хүүхдийн сан болон НҮБХХ нь агаарын бохирдлын хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, иргэдийн амьдрал ахуйд үзүүлсэн нийт нөлөөлөл болон Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулах арга хэмжээний талаарх олон нийтийн танин мэдэхүүд хяналт-шинжилгээ хийх зорилго бүхий хиймэл оюун ухаанаар (AI) дэмжигдсэн, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд суурилсан вэб програм болох "Хазе Газер"-ийг бүтээхэд дэмжлэг үзүүлсэн. Англи, монгол хэл дээр хэвлэгдсэн энэхүү платформ нь хиймэл оюун ухааны тооцоолж, нийгмийн сүлжээний автоматжуулсан зурвасын үйлчилгээгээр дамжуулж цуглуулсан нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн тайлантай хослуулан тодорхой байршлаар гаргасан агаарын чанарын зураглал гаргаж өгдөг.

Инноваци, технологийн боломжийг ашиглах түншлэл

Өөрчлөлтийн агшин нь өмнөх үеийн бэрхшээлийг шийдвэрлэх шинэ боломжуудыг бий болгодог. Дэлхий ертөнц дээрх цахим холболтын хурд, үр ашиг, инноваци нь хүн бүрд, тэр дундаа түүхэндээ гадуурхагдаж ирсэн хүмүүст юу болохуйц байна түүнийгээ дэлгэн нээх боломж олгоно.¹¹

НҮБ-ын энэ удаагийн ХТХ-ий хугацаанд Монгол Улсад мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээ үсрэнгүй хөгжсөн бөгөөд Засгийн газар дижитал өөрчлөлтийг тогтвортой хөгжлийн түлхүүр гэж үзэж байна. Монгол дахь НҮБ нь Олон улсын цахилгаан холбооны байгууллагын дэмжлэгтэйгээр, Дэлхийн банк болон хөгжлийн бусад түншүүдтэй үйл ажиллагаагаа уялдуулж, Засгийн газар, хувийн хэвшилтэй түншлэх замаар цахим-засаглал, цахим-суралцахуй, цахим-хөдөө аж ахуй, телемедицины хандалт буюу хүртээмж, мөн жишээлбэл "Агаарын бохирдолд тавих олон нийтийн хяналт" Хазе Газер санаачилга болон малчдад үзүүлэх хүмүүнлэгийн тусламжид дэмжлэг үзүүлэхэд зориулагдсан ОБЕГ-ын вэб суурьтай гамшгийн менежментийн мэдээллийн нэгдсэн систем, НҮБ-ын сансрын мэдээллийн платформтой гамшгийн менежментийн мэдээллийн нэгдсэн системээр (НҮБ-ОБХАХ) дамжуулан бодит цаг хугацааны мэдээлэлд нэвтрэх боломжийг өргөтгөөд байна.

¹¹ Дижитал харилцан хамаарлын эрин үе, НҮБ-ын ЕНБ-ийн даргын Дижитал хамтын ажиллагааны дээд түвшний комиссын тайлан (2019 оны 6-р сар)

Хүмүүс болон эх дэлхийн төлөөх бодлогын хамтарсан хэлэлцүүлэг

Монгол дахь НҮБ нь ногоон хөрөнгө оруулалт, ногоон технологийг нэвтрүүлэхэд хамтын, уялдаа холбоотой дэмжлэг үзүүлэх чиглэлээр бусад оролцогч талуудтай идэвхтэй хамтран ажиллаж байна. Тухайлбал, НҮБ-ын ПЭЙЖ (PAGE) хөтөлбөр нь ХБНГУ-ын Засгийн газрын дэмжлэгтэйгээр Монгол Улсад ногоон, тогтвортой хөгжлийг хангахад туслалцаа үзүүлэхийн тулд НҮБ-ын системийн таван байгууллагын мэдлэг чадварыг нэгтгэн зангиддаг.

Цаашдын эрч хүчийг бий болгох, энэхүү гол хөтөлбөрийг дэмжих зорилгоор НҮБ-ын Монгол дахь Суурин зохицуулагч болон Монгол Улсын Засгийн газрын ивээл дор "Уур амьсгалын чиглэлээрх ирээдүйтэй түншлэл" цахим форумыг 2020 оны 12-р сарын 22-ны өдөр зохион байгуулав. Энэхүү түншлэлийн механизмыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн тунхаглан зарласан хүлэмжийн хийг бууруулах үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийг 27.2 хувь болгон шинэчилсэн зорилтыг хэрэгжүүлэхэд нь Засгийн газарт хамтын дэмжлэг үзүүлэх хөшүүргийг бий болгох зорилгоор санаачилсан болно. Энэхүү цахим форум нь ихээхэн ач холбогдолтой байсан тул Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдууд, олон улсын байгууллагууд, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, олон улсын банк, санхүүгийн байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, гадаад оролцогчид зэрэг энэ чиглэлээр ажилладаг гол байгууллагуудын 100 гаруй төлөөлөгчдийг уг үйл ажиллагаанд оролцуулж чадлаа.

2.6 НҮБ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАРИЛЦАН УЯЛДАА, ҮР НӨЛӨӨТЭЙ БАЙДАЛ БА ҮР АШИГ

2.6.1. НҮБ-ын системийн байгууллагууд үр дүнд хүрэхийн тулд хэрхэн хамтарч, харилцан уялдаатай ажилласан тухай

Монгол дахь НҮБ-аас “НҮБ-ын нийгэм, эдийн засгийн хариу арга хэмжээний цогц төлөвлөгөө”-г НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын “НҮБ-ын нийгэм, эдийн засгийн яаралтай хариу арга хэмжээний хүрээ”-тэй уялдуулан боловсруулаад байна. Цаашилбал, НҮБ нь эрүүл мэнд, хүмүүнлэг, нийгэм, эдийн засгийн хариу арга хэмжээг зохицуулах НҮБ-ын Суурин зохицуулагчийн эрхлэх ажлын хүрээнд Засгийн газарт КОВИД-19-ийн хариу арга хэмжээ авахад нь зориулж дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ КОВИД-19 хямралаас сэргэх стратеги боловсруулахад хамтран ажиллав.

НҮБ-аас засаглал, нийгмийн хамгаалал, ногоон эдийн засаг, дижитал хувьсгал зэрэг чухал салбаруудад КОВИД-19-ийн нийгэм, эдийн засгийн нарийн төвөгтэй болон тодорхойгүй байдлыг

зохицуулахад Засгийн газарт дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ, шийдвэр гаргагчдыг сэргээн босгох хариу арга хэмжээ авахдаа 2030 оноос хойшихыг харахыг уриаллаа.

НҮБ-ын системийн байгууллагууд, төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд үнэлгээ хийх зэрэг томоохон бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх, КОВИД-19-ийн улмаас дотооддоо болон гадаадад гацсан иргэдээ нутагт нь ирүүлэх, буцаах чиглэлээр хамтран ажиллаж, КОВИД-19-ийн хариу арга хэмжээ авах үеэр гутаан доромжлолоос урьдчилан сэргийлэх, бууруулах зорилготой “Эрсдэлийн мэдээлэл харилцаа ба олон нийтийн оролцоо” аяныг хамтран зохион байгууллаа.

2.6.2. Хамтарсан мэдээлэл харилцаа ба сурталчлан таниулах үйл ажиллагаа

Монгол дахь НҮБ-аас Монгол Улсын ТХЗ-уудыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор хэд хэдэн хамтарсан мэдээлэл харилцаа болон сурталчлан таниулах аяныг зохион байгуулаад байна.

2019-2020 онд НҮБ-75 глобал яриа, хэлэлцүүлгийг ихээхэн чухалчилж ажиллалаа. Монгол дахь НҮБ нь “хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх” хөгжлийн үндсэн зарчимд үндэслэн НҮБ-ын баг хамт олон, төр, засгийн байгууллагууд, хувийн хэвшил, ажил олгогчид, ажил эрхлэгчид, иргэний нийгэм, их дээд сургууль, эрдэм шинжилгээний болон судалгааны байгууллагууд, залуучууд, орон нутгийн иргэд, малчид, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хэвлэл мэдээллийн салбарын 470 төлөөлөл оролцсон 12 удаагийн зөвлөлдөх уулзалт зохион байгуулах замаар нийгмийн бүхий л давхаргын хүмүүсийн дуу хоолойг сонсов.

2020 онд, НҮБ-аас жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх зорилготой 16 хоногийн аяныг “Хүчирхийлэлд үгүй гэж хэлье: Өрх гэр, ажлын байр, олон нийтийн газарт жендэрт суурилсан хүчирхийллийг цэглээ” уриан дор өрнүүлэв. Монгол Улсын Ерөнхий сайд УХүрэлсүхийн ивээл дор, НҮБ-ын Хүн амын сангийн удирдан зохион байгуулсан энэхүү хамтарсан нөлөөлөл, сурталчилгааны аянд Засгийн газрын 20 гаруй түнш байгууллага, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, хөгжлийн болон иргэний нийгмийн түншүүд, хувийн хэвшил, нийгмийн идэвхтэн нөлөөлөгчид, энгийн иргэд хамрагдлаа. Нийгмийн мэдээллийн сүлжээ, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжин явагдсан энэхүү аян наад зах нь 3,938,102 хүнд хүрч чадсан байна.

Монгол дахь НҮБ-ын мэдээлэл харилцааны хамтарсан үйл ажиллагаа нь улсын хэмжээнд КОВИД-19-ийн эрсдэлийн талаарх мэдээлэл харилцааны аян өрнүүлэхэд дэмжлэг үзүүлээ. КОВИД-19-ийг тогтоон барих нийгмийн эрүүл мэндийн аян нь улсын хэмжээнд 2 сая гаруй хүнд хүрсэн. КОВИД-19-өөр өвчилсөн хүмүүсийг гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах үйлдлийн эсрэг аян давхардсан тоогоор 1.5 сая хандалт авсан байна. Нэгдсэн Үндэстний Байгууллагын мэдээлэл харилцааны баг (НҮБМХБ) нь цар тахлын үеэр нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл харилцааг сайжруулах чиглэлээр “Үндэстний эрсдэлийн мэдээлэл харилцаа ба олон нийтийн оролцоог хангах” ажлын хэсэгтэй хамтран ажиллав.

НҮБ-ын удирдлагын багын зүгээс Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан хамтарсан мэдэгдэл хийх, дотоодын хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон төрөл бүрийн нийгмийн сүлжээг ашиглан мэдээлэл дамжуулах замаар Монгол Улсад эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн тэгш байдлыг хамгаалах талаар нөлөөллийн сурталчилгаа хийв. Улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийг хурдасгахын тулд эмэгтэйчүүдийн асар их боломж чадавхад хийх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, мөн жендэрийн тэгш байдлыг хангахыг уриалсан илгээлт болон мэдэгдэл зөвхөн НҮБХХ-ийн мэдээллийн сувгуудаар гэхэд 70,000 орчим хүнд хүрч чадсан байна.



Нүүдэл. Увс аймгийн Тариалан сум

2.6.3. Нийтлэг үйл ажиллагаа

НҮБ-ын удирдлагын баг нь Монгол Улсын ТХЗ-уудыг хангахад чиглэсэн хөгжлийн арга хэмжээг амьдралд хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн сацуу үйл ажиллагааныхаа үр ашгийг дээшлүүлэх, зардлыг бууруулах замаар илүү үр дүнтэй, үр ашигтай байдлыг хангах зорилт тавин ажиллаж байна.

Үйл ажиллагааны удирдлагын баг нь нийтлэг үйл ажиллагааны процессыг оновчтой болгох зорилгоор Үйл ажиллагааны стратегийг хамтран боловсруулж, улмаар 2020 онд батлуулаад байна. Үйл ажиллагааны стратеги боловсруулах ажлын хүрээнд Үйл ажиллагааны удирдлагын баг нь томилолт, хэвлэн нийтлэх, мэдээлэл ба харилцаа холбооны технологийн үйлчилгээ зэрэг Монгол Улсад хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаанд ашиг тусаа өгөх боломжтой нийтлэг үйлчилгээг хамтдаа тодорхойллоо.

Ажилтнуудын цаг болон хүчин чармайлтын үр ашгийг дээшлүүлэх замаар захиргааны зардлыг бууруулах зорилгоор, НҮБ-ын системийн байгууллагуудын идэвхтэй хамтын ажиллагаа, дэмжлэгт суурилсан хэд хэдэн урт хугацаатай нийтлэг үйлчилгээний хамтарсан гэрээ (УХГ) байгуулан хэрэгжүүлж байна.

Үүнд, харуул, хамгаалалтын үйлчилгээний 1 гэрээ (НҮБХХ), барилга, байгууламжийн цэвэрлэгээ, үйлчилгээний 1 гэрээ (НҮБХХ), хэвлэн нийтлэх үйлчилгээний 3 гэрээ (НҮБ-ын Хүүхдийн Сан), тээврийн түрээсийн үйлчилгээний 2 гэрээ (НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага), зочид буудал, зочлохуйн үйлчилгээний 15 гэрээ (НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага), мөн нийтийн хоолны үйлчилгээний 2 гэрээ (НҮБХХ)-г тус тус байгуулаад байна. Эдгээр ажлууд нь хүчин чадал хүрэлцэхгүй зарим байгууллагуудад худалдан авалт богино хугацаанд хийх боломж олгодог болсон.


Эцэст нь орон нутаг дахь хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, авто машины парк ашиглалтыг сайжруулах, нүүрстөрөгчийн ул мөрийг багасгах, ажилтнууд болон тээврийн хэрэгслийн баталгаатай, аюулгүй байдлыг дээшлүүлэх, НҮБ-ын системийн байгууллагуудын үйл ажиллагааны зардлыг бууруулах зорилгоор НҮБХХ, НҮБ-ын Хүн амын сан, НҮБ-ын Хүүхдийн сан тээврийн хэрэгслээ хамтран ашиглах санаачилгыг хэрэгжүүлж байна.

2.7 САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР БА ТОЙМ

2.7.1. Санхүүжилтийн тойм

Хүснэгт 1: Санхүүжилтийн тойм

	БАЙГУУЛЛАГА	НҮБ-ын ХТХ	Шаардлагатай	Нийт бэлэн байгаа, сая ам.доллар			Босгох	Зарцуулалт, сая ам. доллар				
		Амлалт	Дүн	Дүн	Үндсэн	Бусад	Дүн	2017	2018	2019	2020	Дүн
	НИЙТ ДҮН	79.7	173.0	163.0	31.6	131.4	10.1	21.1	22.1	23.3	38.2	104.7
	Үр дүн 1-ийн дүн	34.2	93.9	90.7	15.4	75.2	3.2	10.5	11.7	10.4	21.3	53.8
Үр дүнгийн чиглэл 1	1 НҮБХХААБ	3.7	9.4	9.4	2.5	6.9	-	4.4	1.6	0.9	1.4	8.3
	2 ОУЦЭХБ	1.4	1.9	1.5	-	1.5	0.4	-	0.1	0.1	0.8	1.0
	3 ОУХБ	0.8	2.0	2.0	1.4	0.6	0.1	0.4	0.2	0.3	0.3	1.2
	4 ОУШХБ	-	4.4	4.4	-	4.4	-	0.4	0.7	0.5	1.7	3.3
	5 НҮБОБХАХ	-	0.0	0.0	0.0	-	-	-	-	-	0.0	0.0
	6 НҮБАНДЭЭНК	-	0.2	0.2	-	0.2	0.0	-	-	-	0.2	0.2
	7 НҮБХАСХ	0.1	4.7	4.7	-	4.7	-	0.1	0.1	1.0	-	1.2
	8 НҮБХХ	20.0	33.8	33.5	2.9	30.6	0.3	3.9	2.9	2.5	3.3	12.5
	9 НҮББОХ	1.5	10.1	8.2	-	8.2	1.9	0.3	0.4	0.5	1.7	2.9
	10 НҮБШУСБ	0.3	0.9	0.7	0.4	0.2	0.3	-	0.1	0.1	0.4	0.5
	11 НҮБХС	0.1	7.1	6.8	3.2	3.5	0.3	0.2	0.6	1.4	1.6	3.7
	12 НҮБАУХБ	2.3	11.4	11.4	-	11.4	-	0.8	5.2	0.9	4.1	10.9
	13 ДХХ	-	0.3	0.3	-	0.3	-	-	-	0.2	0.1	0.3
	14 ДЭМБ	4.1	7.7	7.7	2.1	5.5	-	-	-	2.1	5.5	7.7
	Үр дүн 2-ын дүн	37.9	53.6	47.3	10.2	37.0	6.3	6.1	6.4	8.0	11.5	32.0
Үр дүнгийн чиглэл 2	1 НҮБХХААБ	-	8.2	8.2	1.2	7.0	-	0.2	0.1	0.2	0.9	1.4
	2 ОУЦЭХБ	1.7	1.3	1.2	-	1.2	0.1	0.0	0.7	0.4	0.1	1.2
	3 ОУХБ	0.8	0.9	0.9	0.0	0.9	-	0.0	0.0	-	0.3	0.3
	4 ОУШХБ	-	0.8	0.8	-	0.8	-	-	-	0.1	0.4	0.4
	5 НҮБХАСХ	0.1	0.3	0.3	-	0.3	-	0.1	0.1	-	0.2	0.3
	6 НҮБХДХВ	-	0.0	0.0	0.0	-	-	0.0	-	-	-	0.0
	7 НҮБШУСБ	0.3	3.3	1.4	1.1	0.3	1.9	0.1	0.2	0.3	0.7	1.3
	8 НҮБХАС	9.3	7.6	7.6	1.3	6.3	-	0.9	1.7	2.3	2.3	7.2
	9 НҮБХС	18.5	23.8	19.5	1.0	18.5	4.3	1.9	1.9	3.3	5.5	12.5
	10 ДЭМБ	7.2	7.3	7.3	5.5	1.7	0.0	2.9	1.6	1.4	1.3	7.3
	Үр дүн 3-ын дүн	7.6	25.5	25.0	5.9	19.1	0.5	4.5	4.1	4.8	5.5	18.9
Үр дүнгийн чиглэл 3	1 ОУХБ	1.0	1.2	1.2	0.4	0.7	-	0.3	0.1	0.2	0.1	0.7
	2 ОУШХБ	-	1.8	1.8	-	1.8	-	0.2	0.1	0.0	0.8	1.1
	3 НҮБХАСХ	-	0.1	0.1	-	0.1	-	0.0	0.1	-	-	0.1
	4 НҮБХХ	0.8	8.7	8.7	0.6	8.1	-	1.0	1.7	2.1	1.4	6.2
	5 НҮБШУСБ	0.4	0.4	0.3	-	0.3	0.1	-	-	-	0.3	0.3
	6 НҮБХАС	5.0	9.8	9.7	4.0	5.7	0.2	2.6	1.6	2.1	2.0	8.3
	7 НҮБХС	0.5	3.5	3.2	0.8	2.4	0.3	0.3	0.4	0.5	0.9	2.1
	8 ДЭМБ	0.1	0.1	0.0	0.0	-	0.0	0.0	0.0	0.0	-	0.1



Зураг 18: НҮБ-ын ХТХ-д тусгагдсан анхны төсөв ба 2017-2020 оны санхүүжилт, зарцуулалт сая ам. доллараар



Зураг 19: Үр дүнгийн чиглэлээр харуулсан Санхүүгийн эх үүсвэр

Зураг 20: НҮБ-ын системийн байгуулага тус бүрээр гаргасан 2017-2020 оны зарцуулалт






Зураг 21: Үр дүн 1-ийн зарцуулалт, зорилтоор 2017-2020



Зураг 22: Үр дүн 2-ын зарцуулалт, зорилтоор 2017-2020




Зураг 23: Үр дүн 3-ын зарцуулалт, зорилтоор 2017-2020

2.7.2. Санхүүжилтийн эх үүсвэр

НҮБ-ын системийн байгууллагууд нийлээд 70 өөр эх үүсвэрээс нийт 163 сая доллар татан төвлөрүүллээ. Санхүүжилтийн эх үүсвэрийг нийт санхүүжилтэд эзлэх хувийн жингийн хамт Зураг 24-т тоймлон үзүүлэв.

Зураг 24: 2017-2020 оны хооронд нийт босгосон хөрөнгө- эх үүсвэрээр:



Глобал төрөлжсөн сангууд	Дүн (сая ам \$)
1 ДДБОС	29.2
2 ДЦС	5.3
3 НҮБОХДҮХХЯБХ ОТТИС	3.6
4 ТХЗ-С	3.0
5 ДДБС	2.4
6 ДДХШТС	1.4
7 ОБХАХТС	1.1
8 УАНС	1.1
9 НҮБКОТТИС	1.1
10 ДДУАЦЭАС	1.0
11 ЯБОСС	0.8
12 БОЯБСИС	0.7
13 БНСУОУЭМТҮС	0.6
14 ХЭХЭС	0.5
15 ДДХХС	0.4
16 ДДЭМС	0.4
17 МПХОТС	0.4
18 ДДНХС	0.2
19 ОУХБМСА	0.2
20 ПЭЙЖ ИС	0.2
21 ЕАХЭС	0.2
22 БТДДТ	0.1
23 ТХАБХ	0.1
24 ҮХТХНТ - УАӨҮАСБ	0.0
25 ДДЖС	0.0

Улс орон/ засгийн газрын байгууллагууд	Дүн (сая ам \$)
1 ШХА	3.37
2 ЕК	2.41
3 Канад	1.22
4 БНСУОУХАА	1.03
5 Люксембург	0.78
6 АНУОУХА	0.68
7 ОУУАС	0.51
8 Нидерланд	0.43
9 ХХГХТА	0.33
10 Япон	0.30
11 ГАВИ ВЭ	0.29
12 ШБОХА	0.18
13 ШОУХХАА	0.13
14 БНСУ	0.06
15 Монако	0.05
16 АОУХЯ	0.04
17 ЕКОУХАХБ	0.03
18 АОУХА	0.2
19 Денмарк	0.2
20 ИБУИНВУ	0.2
21 АГХХЯ	0.2

Хувийн салбар	Дүн (сая ам \$)
1 БМГС	2.1
2 ОТ ХХК	0.9
3 ГОХХДС	0.6
4 ХССБННС	0.2

ТББ-ууд	Дүн (сая ам \$)
1 НҮБХСБНСУУХ	1.4
2 БНСУ-ын ХС	1.0
3 НҮБХСКҮХ	0.5
4 НҮБХССАУХ	0.4
5 НҮБХСИҮХ	0.4
6 ЯСДНХ	0.3
7 НҮБХСАУХ	0.3
8 НҮБХСЯУХ	0.2
9 НҮБХСШҮХ	0.1

3

НҮБ-ЫН УДИРДЛАГЫН БАГИЙН 2022 ОНЫ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

НҮБ нь 2021 онд КОВИД-19-өөс үүдэлтэй хямралаас сэргээн босгох ажилд үзүүлж ирсэн дэмжлэгээ үргэлжлүүлж, Монгол Улсад 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн чиглэлийн үйл ажиллагаанд анхаарлаа хандуулах болно.

НҮБ-ын ХТХ-ний Үр дүнгийн чиглэл 1-ийн хүрээнд, НҮБ-аас ТХЗ-уудын нэгдсэн санхүүжилт, төсөвлөлт, нутагшуулалт, хяналт-шинжилгээ болон үнэлгээ хийх чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ. Түүнчлэн, НҮБ нь ирэх хоёр жилийн хугацаанд, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны засаглал, биологийн олон янз байдал, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, агаарын бохирдол, бичил уурхайд мөнгөн ус ашиглахыг таслан зогсоох, усан хангамжийн найдвартай байдал, хог хаягдлын менежментэд анхаарлаа хандуулна.

Үүний нэгэн адил, НҮБ нь хүртээмжтэй, төрөлжсөн эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, гамшгийг даван туулах чадвар, Монгол Улсын олон улсын болон дотоод дахь шилжилт хөдөлгөөнөөс гадна төрөлжсөн, нэмүү өртөг шингэсэн мал аж ахуйн бүтээгдэхүүний экспорт, газар ашиглалт, ногоон эдийн засгийн чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг мөн чухалчилна.

НҮБ-ын ХТХ-ний Үр дүнгийн чиглэл 2-ын хүрээнд, ус, ариун цэвэр, эрүүл ахуй, бэлгийн замаар дамжих халдварт өвчин болон ХДХВ-ээс урьдчилан сэргийлэх, өсвөр насныхны сэтгэцийн эрүүл

мэндийн үйлчилгээ, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн чанартай үйлчилгээ, эрүүл мэндийн ажилтныг хамгаалах, эх, нялхсын эрүүл мэндийн үйлчилгээг дэмжиж ажиллана. Түүнчлэн НҮБ-ын оролцоо нь ТХЗ 4-ийг нутагшуулах, боловсролын салбарыг дэмжих, энэ хүрээнд бага насны хүүхдийн өсөлт хөгжил, бага насныхан болон өсвөр үеийнхний боловсрол, техник мэргэжлийн боловсрол, сургалтад чиглэгдэх болно. Мөн адил, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын тухай хууль тогтоомжийн шинэчлэл, нийгмийн эмзэг бүлгийн иргэд болох малчид, дотоодын шилжин суурьшигчдад үзүүлэх нийгмийн суурь үйлчилгээнд дэмжлэг үзүүлнэ. Үүний нэгэн адилаар, НҮБ нь хүнсний хяналтын менежмент ба аюулгүй байдлын үр дүнтэй систем, цахим хөдөө аж ахуйг хөгжүүлэх үндэсний стратеги, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээ, малын эрүүл мэнд, шим тэжээлийн үйлчилгээг дэмжих болно.

НҮБ-ын ХТХ-ний Үр дүнгийн чиглэл 3-ын хүрээнд, Монгол Улсад иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ, хүүхэд, эмэгтэйчүүд, охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах тогтолцоо, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн зах зээлийн засаглал, хөдөлмөр эрхлэх эрхийн асуудлаар дэмжлэг үзүүлэх болно. Мөн, НҮБ нь амьдрах ухааны боловсрол, залуучуудын сүлжээгээр дамжуулан өсвөр насныхан, залуучуудын хөгжил, тэдэнд боломж олгох зэрэг чиглэлээр дэмжлэг үзүүлж ажиллах болно.



Амьдрал ахуйгаа дээшлүүлэх боломж хайж иргэд орон нутгаас хот суурин газрыг зорих нь ихсэв.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АГХХЯ	Австралийн гадаад харилцаа, худалдааны яам
АНУОУХА	АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг
АОУХА	Австралийн олон улсын хөгжлийн агентлаг
АОУХЯ	Английн Олон Улсын Хөгжлийн Яам
АҮАБХУОУП	Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын пакт
АХБ	Азийн хөгжлийн банк
БОЯБСИС	НҮБХХ Биологийн олон янз байдлыг санхүүжүүлэх итгэлцлийн сан
БМГС	Билл ба Мелинда Гэйтсийн сан
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНСУОУХАА	Бүгд Найрамдах Солонгос Улсын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг
БНСУОУЭМТҮС	Бүгд Найрамдах Солонгос Улсын Олон улсын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний сан
БНСУ-ын ХС	БНСУ-ын хүүхдийн сан
БТДДТ	Боловсролын төлөөх даян дэлхийн түншлэл
ГАВИ ВЭ	ГАВИ Вакцины эвсэл
ГОХДС	Говь Оюу хөгжлийг дэмжих сан
ДДБӨС	Даян дэлхийн байгаль орчны сан
ДДБС	Даян дэлхийн боловсролын сан
ДДЖС	Даян дэлхийн жендэрийн сан
ДДНХИ	Даян дэлхийн ногоон хөгжлийн институт
ДДНХС	Даян дэлхийн нийгмийн хүртээмжийн сан
ДДУАЦЭАС	Даян дэлхийн ус, ариун цэвэр, эрүүл ахуйн сан
ДДХХС	Даян дэлхийн хүүхэд хамгаалах сан
ДДХШТС	Даян дэлхийн хүнсний шим тэжээлийн сан
ДДЭМС	Даян дэлхийн эрүүл мэндийн сан
Денмарк	Дани Улсын Засгийн газар
ДХХ	Дэлхийн хүнсний хөтөлбөр
ДЦС	Дасан зохицлын сан
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЕАХЭС	Европын ардчилал, хүний эрхийн сан
ЕКОУХАХБ	Европын Комиссын Олон улсын хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
ЕХ	Европын холбоо
ИБУИНВУ	Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс
ИУТЭОУП	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
Канад	Канад Улсын Засгийн газар
КОВИД-19 ОТТИС	НҮБ-ын КОВИД-19 Олон талт түншлэлийн итгэлцлийн сан
Люксембург	Люксембургын Их Гүнт Улсын Засгийн газар
Монако	Монако Улсын Засгийн газар
МПХОТС	Монреал протоколыг хэрэгжүүлэгч олон талт сан
Нидерланд	Нидерланд Улсын Засгийн газар
НҮБАНДЭЗНК	НҮБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засаг, нийгмийн комисс

НҮБАҮХБ	НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага
НҮББОХ	НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр
НҮББШУСБ	НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага
НҮБКОТТИС	НҮБ-ын КОВИД-19 ОТТИС
НҮБОБХАХ	НҮБ-ын Гамшгийн менежмент ба онцгой байдлын хариу арга хэмжээний сансарт суурилсан мэдээллийн платформ
НҮБОХДҮХХЯБХ ОТТИС	НҮБ-ын Ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах хөтөлбөр ба Олон талт түншүүдийн итгэлцлийн сан
НҮБХАС	НҮБ-ын Хүн амын сан
НҮБХАСХ	НҮБ-ын Хүн амын суурьшлын хөтөлбөр
НҮБХДХВ	НҮБ-ын ДОХ/ХДХВ-ийн хамтарсан хөтөлбөр
НҮБХС	НҮБ-ын Хүүхдийн сан
НҮБХСАҮХ	НҮБ-ын Хүүхдийн сангийн Англи дахь Үндэсний хороо
НҮБХСИҮХ	НҮБ-ын Хүүхдийн сангийн Итали дахь Үндэсний хороо
НҮБХСКҮХ	НҮБ-ын Хүүхдийн сангийн Канад дахь Үндэсний хороо
НҮБХСӨСҮХ	НҮБ-ын Хүүхдийн сангийн Өмнөд Солонгос дахь Үндэсний хороо
НҮБХССАҮХ	НҮБ-ын Хүүхдийн сангийн Саудын Араб дахь Үндэсний хороо
НҮБХСШҮХ	НҮБ-ын Хүүхдийн сангийн Швед дэх Үндэсний хороо
НҮБХС-ын БНСУ ҮХ	НҮБ-ын Хүүхдийн сангийн БНСУ дахь Үндэсний хороо
НҮБХСЯҮХ	НҮБ-ын Хүүхдийн сангийн Япон дахь Үндэсний хороо
НҮБХХ	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр
НҮБХХААБ	НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
ОБХАХТС	Онцгой байдлын хариу арга хэмжээний төв сан
ОТ ХХК	Оюу толгой компани
ОУУАС	Олон улсын уур амьсгалын санаачилга
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ОУХБМСА	Олон улсын химийн бодисын менежментийн стратегийн арга
ОУЦЭХБ	Олон улсын цөмийн эрчим хүчний байгууллага
ОУШХБ	Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага
ПЭЙЖ ИС	Ногоон эдийн засгийн төлөөх түншлэлийн Олон талт итгэлцлийн сан
СХС	Солонгосын хүүхдийн сан
ТХАБХ	Техникийн хамтын ажиллагааны байнгын хөтөлбөр
ТХЗ-С	Тогтвортой хөгжлийн зорилтууд - Сан
УАНС	Уур амьсгалын ногоон сан
ҮХТХНТ - УАӨҮАСБ	Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн түншлэл - УАӨҮАСБ
ХБХЭК	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц
ХССБННС	Хувийн салбарын санхүүжилт босголт – нэгдсэн нөөц сан
ХХГХТА	АНУ-ын Гадаад хэргийн яамны хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх алба
ХХУЗГ	Хэд хэдэн улсын Засгийн газар
ХЭК	Хүүхдийн эрхийн тухай конвенц
ХЭХЭС	Хүүхдийн эсрэг хүчирхийллийг цэглэх сан
ЦАОУК	Цагаач ажилчид ба тэдгээрийн гэр бүлийг хамгаалах тухай олон улсын
ШБОХА	Шведийн байгаль орчныг хамгаалах агентлаг
ШОУХХАА	Шведийн олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны агентлаг
ШХА	Швейцарын хөгжлийн агентлаг
ШЭЗЯ	ШХУ-ын Эдийн засгийн асуудал эрхэлсэн яам

ЭАБХУК
ЭЗНСЭОУП

Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц
Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт
конвенц

ЯБОСС
Япон
ЯСДНХ

Ядуурал-Байгаль орчны санаачилгын сан
Япон Улсын Засгийн газар
Японы сайн дурын нэмэр хандив

